

НИЙСЛЭЛИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	6
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	8
БҮЛЭГ 1. НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ 4 УДАА ТОДОТГОЛ ХИЙСЭН НЬ ТӨСВИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.	9
1.1.Хотын болон дүүргийн төсөв.	11
1.2. Дүүргүүдэд олгох санхүүгийн дэмжлэг, дүүргүүдийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого;.....	15
1.3.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого.....	16
1.4.Нийслэл, дүүргийн ОНХС-д олгох шилжүүлэг;.....	16
1.5. Улсын төсөвт төлөх зээлийн эргэн төлөх үндсэн болон хүүгийн төлбөр.....	16
БҮЛЭГ 2. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО 90.6 ХУВИЙН БИЕЛЭЛТТЭЙ БАЙНА.	17
2.1 Нийслэлийн нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг 396,918.7 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар дутуу биелүүлсэн байна.	17
2.2 Хотын шуудын орлого 88.3 хувийн гүйцэтгэлтэй байна.....	20
2.3 Дүүргүүдийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2 дүүрэг 2.7-25.8 хувиар давуулан, 7 дүүрэг 2.9-11.6 хувиар дутуу биелүүлсэн байна.....	22
БҮЛЭГ 3. ЗАРИМ ОНӨААН-ҮҮД ЭДИЙН ЗАСГИЙН ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.	24
БҮЛЭГ 4. НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ НИЙТ ЗАРЛАГЫН 53.0 ХУВИЙГ ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ ЭЗЭЛЖ БАЙНА.....	27
4.1 Нийт зардал төлөвлөсөн түвшинд бүрэн хүрээгүй байгаа нь хөрөнгө оруулалттай холбоотой төсөл, арга хэмжээний хэрэгжилт болон үр ашгийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.	27
4.2 Төсвийн байгууллагын батлагдсан төсөвт тусган санхүүжүүлэх боломжтой зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна.	34
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан үр ашигтай, ил тод, сахилга баттай, хариуцлагатай байх зарчмуудыг бүрэн хангаж ажиллаагүй байна.	36
4.4 Аудитад хамрагдсан байгууллагуудын төрийн санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй зөрчил нь өмнөх оноос 35,070.6 сая төгрөг буюу 8.0 хувиар буурсан байна.	37
БҮЛЭГ 5. НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ ӨМНӨХ ОНООС 32.3 ХУВИАР ӨССӨН БАЙНА.	39
5.1 Улсын төсвийн 2025 оны хөрөнгөөр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа 28 төсөл, арга хэмжээний 86,513.3 сая төгрөгийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж Сангийн яаманд албан бичгээр болон улсын хөрөнгө оруулалтын цахим системээр уламжлан шийдвэрлүүлсэн байна.	39
5.2 Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, хугацаа дууссан барьцааг төсөвт төвлөрүүлээгүй байна.	39
5.3 Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар улсын төсвийн байгууллагад хөрөнгө бэлтгэсэн, хугацаа дууссан барьцааг төсөвт төвлөрүүлээгүй байна.....	42
БҮЛЭГ 6. НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ.....	44
ДҮГНЭЛТ.....	46
ЗӨВЛӨМЖ.....	48
ХАВСРАЛТ.....	49



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Нийслэлийн 2025 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн
аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/146 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын шалгагдагч байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэрийг шинэчлэн батлах тухай, А/175 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалт, 2026 оны А/33 дугаартай "Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай" тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1."Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайланг (НТАГ-2026/02-11/СТА-НА-НТГ) хавсралтаар баталсугай.

2.Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг 2026 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д зөвлөсүгэй.

3.Аудитаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2026 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер (Х.Түвшинбаяр)-т үүрэг болгосугай.

4.Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус тус хүргүүлсүгэй.



Г.НАНДИНЖАРГАЛ

1426010014

C:\Users\inarangua\Desktop\Бичиг хэргээр 2026\2026\word\tushahil\№28-Тайлан баталгаажуулах тухай.docx

Товчилсон үгийн жагсаалт

1	ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
2	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
3	БГД	Баянгол дүүрэг
4	БЗД	Баянзүрх дүүрэг
5	БНД	Багануур дүүрэг
6	БХД	Багахангай дүүрэг
7	ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
8	ЗД	Засаг дарга
9	ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
10	ЗЗАГ	Зам засвар арчлалтын газар
11	ЗХУТ	Замын хөдөлгөөний удирдлагын төв
12	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
13	НАГ	Нийслэлийн Архивын газар
14	НАОБТГ	Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар
15	НБОГ	Нийслэлийн Байгаль орчны газар
16	НД	Налайх дүүрэг
17	НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
18	НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
19	НИТХ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал
20	ННТБГ	Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар
21	НОСК	Нийслэлийн Орон сууцны корпорац
22	НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
23	НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
24	НХТГ	Нийслэлийн Хот тохижилтын газар
25	НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
26	НТЗАБ	Нийслэлийн Төр захиргааны авто бааз
27	ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
28	ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
29	ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
30	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
31	ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
32	ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
33	СБД	Сүхбаатар дүүрэг
34	СХД	Сонгинохайрхан дүүрэг
35	СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
36	ТАХ	Төсөл, арга хэмжээ
37	ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
38	ТБОХӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
39	ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
40	ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
41	ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
42	УБ	Улаанбаатар
43	УСУГ	Ус сувгийн удирдах газар
44	УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар

45	ҮЦХ	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн
46	ХК	Хувьцаат компани
47	ХУД	Хан-Уул дүүрэг
48	ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
4	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
50	ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
51	ЧД	Чингэлтэй дүүрэг

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Нийслэл дэх Төрийн аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын зорилт

Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаажуулалтаар нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад мэдээлэл хэрэглэгчийг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Аудитын хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-54.5.5-т заасны дагуу нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Үүнд:

- Нийслэлийн 2025 оны төсвийн гүйцэтгэл;
- Дүүргийн 2025 оны төсвийн гүйцэтгэл;
- Нэмэлт төсвийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан;
- Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ;
- Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт;
- Өмнөх оны зөвлөмжийн биелэлт.

Аудитад нийслэл, дүүргүүдийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, НЗДТГ, 9 дүүргийн СТСХ-ээс ирүүлсэн судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалыг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын завар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, аудитын горим сорилыг хэрэгжүүлэв. Үүнд нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын СТСХ-ийн болон холбогдох бусад байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, судалгаа, асуулга авах зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитын тайланд нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн гүйцэтгэл, Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн болно. Аудитын холбогдох мэдээлэл, ажлын баримтыг хавсаргав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын багц хуулиуд;
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль;
- Татварын багц хуулиуд;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Тухайн жилийн төсвийн бодлого, чиглэл, зарчим;
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.

Засгийн газрын дараах тогтоол, шийдвэрүүдийг 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам” 29 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2024 оны “Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, аудитын менежер Д.Отгонбаяр нар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор, аудиторууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолоор төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,971,827.1 сая төгрөг, төсвийн зарлагыг 5,957,699.6 сая төгрөгөөр баталсан байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/132 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,567,511.6 сая төгрөг, төсвийн зарлагыг 4,567,511.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Нийслэлийн 2025 оны төсөвт нийт 4,222,915.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 5,834,517.6 сая төгрөгийг зардалд зарцуулахаар баталснаас гүйцэтгэлээр 3,825,996.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 4,526,181.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-ний зардлыг 1,687,889.9 сая төгрөг, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-ний зардлыг 156,293.3 сая төгрөг, нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-ний зардлыг 686,549.9 сая төгрөг, нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-ний зардлыг 29,410.2 сая төгрөг, он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын ТАХ-ний зардлыг 395,330.0 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нийслэлийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 130,762.8 сая төгрөгөөр баталсныг бүрэн төвлөрүүлсэн байна.

Гадаадын зээл тусламжаар нийслэлд хэрэгжиж байгаа дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу тайлант онд үндсэн төлбөрт 54,345.0 сая төгрөг, хүүгийн төлбөрт 18,641.3 сая төгрөгийг төлөхөөр төсөвт тусгасныг бүрэн төлсөн байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/02 дугаар тогтоолоор "Туулын хурдны зам" төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 419,225.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,964,788.8 сая төгрөг болгож, 25/70 дугаар тогтоолоор 1,048,480.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,384,013.8 сая төгрөг болгож тус тус өөрчлөлт оруулсан байна.

БҮЛЭГ 1. НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ 4 УДАА ТОДОТГОЛ ХИЙСЭН НЬ ТӨСВИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу Нийслэлийн Засаг дарга 2025 оны төсвийн төсөл боловсруулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нийслэлийн 2025 оны төсвийн төслийг боловсруулж төсвийн орлогыг 3,018,482.4 сая төгрөгөөр, зардлыг 6,027,159.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Сангийн яам нийслэлийн 2025 оны төсвийн суурь орлогыг 3,417,225.8 сая төгрөг, суурь зарлагыг 3.226,442.5 сая төгрөгөөр хянасан байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нийслэлийн 2025 оны төсвийн төслийг боловсруулж төсвийн орлогыг 3,856,382.4 сая төгрөгөөр, зардлыг 3,495,717.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлсэн. Нийслэл дэх Төрийн аудитын газар төсвийн төсөлд дүгнэлт гаргаж НИТХ-д 2, НЗД-д 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийслэлийн 2025 оны төсвийн төслийг дараах үндсэн чиглэл, бодлогыг баримталж боловсруулсан байна. Үүнд:

- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлж, хотын эдийн засгийг тэлэх бодлогыг хэрэгжүүлэх;
- Гэр хорооллыг орон сууцжуулж, агаар орчны бохирдлыг бууруулах;
- Улаанбаатар хотын холбоос замуудыг нэмэгдүүлэн, нийтийн тээврийн салбарт цогц шинэчлэл хийх замаар авто замын түгжрэлийг бууруулах;
- Өнгөрсөн он жилүүдэд эхлүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн дуусгаж, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1, 67 дугаар зүйлийн 67.3-т тус тус заасны дагуу төсвийн төслийг Ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулж, нийт 147,542 иргэнээс санал ирүүлснийг санхүү, төсвийн боломжит эх үүсвэрийн хүрээнд судлан төсвийн төсөлд тусгасан байна.

Нийслэлийн 2025 оны төсөв “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”-нд нийцсэн байна.

Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд 5 зорилт 382 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Хүснэгт 1. 2025 оны зорилт

№	Нийслэлийн хөгжлийн бодлого зорилт	Төлөвлөсөн арга хэмжээ	Хөрөнгө оруулалт шаардлагатай
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	111	95
2	Хүний хөгжлийн бодлого	107	87
3	Эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого	52	45
4	Ногоон хөгжлийн бодлого	50	47
5	Засаглалын бодлого	62	50

Эх сурвалж. Төсвийн төслийн тайланд санал хүргүүлсэн аудитын тайлан

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нийслэлийн 2025 оны төсвийн суурь орлогыг 3,198,503.2 сая төгрөг, суурь зарлагыг 3,198,503.2 сая төгрөг, улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогыг 130,762.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогыг 39,536.7 сая төгрөгөөр баталсныг 2025 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр нийслэлийн 2025 оны төсвийн суурь орлогыг 3,203,373.0 сая төгрөг, суурь зарлагыг 2,767,497.0 сая төгрөг, улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогыг 130,762.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогыг 39,536.7 сая төгрөгөөр тус тус баталжээ.


НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоолоор нийслэлийн 2025 оны төсвийн орлогыг 3,010,186.1 сая төгрөгөөр, зардлыг 5,971,827.1 сая төгрөгөөр баталсан байна.

Нийслэлийн нэгдсэн төсөв нь хотын төсвийн болон дүүргүүдийн төсвөөс бүрддэг бөгөөд дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

- Хотын болон дүүргүүдийн төсөв;
- Дүүргүүдэд олгох санхүүгийн дэмжлэг;
- Дүүргүүдийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого;
- Улсын төсөвт төвлөрүүлэх орлого;
- Нийслэл, дүүргийн ОНХС-д олгох шилжүүлэг;
- Улсын төсөвт төлөх зээлийн эргэн төлөх үндсэн болон хүүгийн төлбөр.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2[1]-т заасны дагуу НИТХ-ын 2025 оны 25/50, 25/106, 25/113, 25/132 дугаар тогтоолуудаар нийслэлийн төсөвт 4 удаа өөрчлөлт оруулсан байна.

Дүрслэл 1. Нийслэлийн төсвийн бүтэц, сая төгрөгөөр



Эх сурвалж. НИТХ-ын 2025 оны 25/50, 25/106, 25/113, 25/132 дугаар тогтоолууд

1. НИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 25/50 дугаар тогтоолоор газрын төлбөр, торгуулийн орлого, өмч хувьчлалын орлого зэргийг 101,420.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зардлыг 184,646.3 сая төгрөгөөр бууруулсан. Үүнээс голлох зардал нь:

Урсгал зардал: ЗДТГ-ын зардлыг 55,466.7 сая төгрөгөөр, Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээнд 15,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд 13,000.0 сая төгрөгийг шинээр тусгажээ.

Хөрөнгийн зардал: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг 160,930.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2024-2025 оны он дамжин санхүүжих хөрөнгийн дүнг 245,000.0 сая төгрөгөөр бууруулсан байна.

2. НИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 25/106 дугаар тогтоолоор газрын төлбөр, өмч хувьчлалын орлогыг нийт 97,233.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зардлыг 3,746.5 сая төгрөгөөр бууруулсан байна. Үүнээс голлох зардал:

Урсгал зардал: Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээний зардлыг 1,208.9 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хөрөнгийн зардал: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг 3,746.5 сая төгрөгөөр, 2024-2025 оны дамжин санхүүжих хөрөнгийн хэмжээг 102,304.4 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3. НИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 25/113 дугаар тогтоолоор зардлыг нийт 148,561.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнээс голлох зардал:

Урсгал зардал: Халаалтын үнийн зөрүүг 997.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хөрөнгийн зардал: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг 13,817.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2024-2025 оны дамжин санхүүжих хөрөнгийн хэмжээг 14,956.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

4. НИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 25/132 дугаар тогтоолоор зардлыг нийт 1,300,987.7 сая төгрөгөөр бууруулсан байна. Үүнээс голлох зардал:

Урсгал зардал: НЗДТГ-ын үйл ажиллагааны зардлын нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээг 16,000.0 сая төгрөгөөр өсгөж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны нөөцийн махны хүүгийн хөнгөлөлтийг, Агаар орчны бохирдолтой тэмцэх газрын сайжруулсан түлшний тээвэрлэлт, хадгалалт хяналт шалгалтын зардал, борлуулалтын урамшууллыг, Нийтлэг үйлчилгээний газрын зардлыг нийт 14,199.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хөрөнгийн зардал: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг 50,000.0 сая төгрөгөөр, Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 1,300,987.7 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Тайлант онд нийслэлийн төсөвт нийт 4 удаа тодотгол хийсэн нь төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулаагүй, холбогдох судалгаа, шинжилгээнд суурилаагүй байна.

1.1. Хотын болон дүүргийн төсөв.

НИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 25/132 дугаар тогтоолоор орлогыг 4,235,378.8 сая төгрөгөөр, зардлыг 5,834,517.6 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 2. Нийслэлийн төсөвт орсон өөрчлөлт, (сая төгрөгөөр)


Үзүүлэлт	Анх баталсан (НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоол)	Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр баталсан (НИТХ-ын 2025 оны 25/132 дугаар тогтоол)	Зөрүү /2-1/	
			дүн	хувь
А	1	2	3	4
Нийт эх үүсвэр	5,971,827.1	4,567,511.6	(1,404,315.5)	76.5
Төсвийн орлого	1,563,073.6	1,770,045.2	206,971.6	113.2
Татварын орлого	1,050,723.2	1,137,423.2	86,700.0	108.3
Татварын бус орлого	512,350.4	632,622.0	120,271.6	123.5
Тусламжийн орлого	1,447,112.6	1,433,251.1	(13,861.5)	99.0
Урьд оны үлдэгдэл	2,961,641.0	1,364,215.3	(1,597,425.8)	46.1
Нийт зарлага	5,971,827.1	4,567,511.6	(1,404,315.5)	76.5
Урсгал зардал	1,165,475.5	1,377,741.1	212,265.6	118.2
Хөрөнгийн зардал	4,735,354.7	2,986,863.6	(1,748,491.1)	63.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	56,869.4	54,345.0	(2,524.4)	95.6
Улсад төвлөрүүлэх орлого	0.0	130,762.8	130,762.8	100.0
Дүүргүүдэд олгох санхүүгийн дэмжлэг	14,127.5	17,799.1	3,671.6	76.5

Эх сурвалж. НИТХ-ын тогтоолууд

Нийслэлийн төсвийн орлогын 41.8 хувийг хотын төсөв бүрдүүлж 78.0 хувийг зарцуулахаар, дүүргүүд орлогын 58.2 хувийг бүрдүүлж 22.0 хувийг зарцуулахаар төлөвлөжээ.

Дүрслэл 2. Нийслэлийн 2025 оны батлагдсан төсөв, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Орлого		Зардал	
	Дүн	Хувийн жин /хувиар/	Дүн	Хувийн жин /хувиар/
Хотын төсөв	1,770,045.2	41.8%	4,549,712.5	78.0%
Дүүргүүдийн төсөв	2,465,333.6	58.2%	1,284,805.1	22.0%
Нийслэлийн нэгдсэн төсөв	4,235,378.8	100.0%	5,834,517.6	100.0%



Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийслэлийн төсвийн 65.2 хувийг хөрөнгийн зардал, 34.8 хувийг урсгал зардал эзэлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 "зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөж батлах" зарчим болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "тогтвортой орчныг бүрдүүлэх, инфляцыг хязгаарлах" гэсэн зорилттой нийцэхгүй байна.

Дүрслэл 3. Нийслэлийн төсвийн бүтэц 2023-2025 он




Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дүрслэл 4. Олон улсын хотуудын жишиг

ОЛОН УЛСЫН ЖИШИГ: ХОТЫН ТӨСВИЙН БҮТЭЦИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Урсгал зардал ба Хөрөнгийн зардлын эзлэх хувь

■ Урсгал зардал (%) ■ Хөрөнгийн зардал (%)



Батлагдсан төсвийг өмнөх оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн орлого 1,192,296.7 сая төгрөг буюу 39.2 хувиар (2024 онд 3,043,082.1 сая төгрөг, 2025 онд 4,235,378.8 сая төгрөг), зарлага 2,472,238.4 сая төгрөгөөр буюу 73.5 хувиар (2024 онд 3,362,279.2 сая төгрөг, 2025 онд 5,834,517.6 сая төгрөг) тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан судалгаа, (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Орлого				Зардал			
	2024 оны гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	зөрүү /өссөн +, буурсан -/	хувь	2024 оны гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	зөрүү /өссөн +, буурсан -/	хувь
Хотын төсөв	1,025,868.4	1,770,045.2	744,176.8	72.5	2,468,798.8	4,549,712.5	2,080,913.7	84.3
Дүүргүүдийн төсөв	2,017,213.7	2,465,333.6	448,119.9	22.2	893,480.5	1,284,805.1	391,324.6	43.8
Нийслэлийн нэгдсэн төсөв	3,043,082.1	4,235,378.8	1,192,296.7	39.2	3,362,279.2	5,834,517.6	2,472,238.4	73.5

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны гүйцэтгэлээс хотын төсвийн орлого 72.5 хувиар, зардал 84.3 хувиар, дүүргүүдийн төсвийн орлого 22.2 хувиар, зардал 43.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Цалин хөлс болон түүнтэй адилтгах бусад нэр төрлийн ХХОАТ-ыг тайлант онд 1,568,405.8 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 940,400.0 сая төгрөг, газрын төлбөрийг 102,361.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс орлогыг 1,192,296.7 сая төгрөг буюу 39.2 хувиар нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна.

Нийслэлийн авто замын түгжрэл болон сайжруулсан түлшний тээвэрлэлт, борлуулалт, хадгалалт, хяналт шалгалтын зардал, зээлийн төлбөр, он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл, санхүүжилт, 2025 онд нийт 17 байгууллага шинээр байгуулагдсан зэрэгтэй уялдуулан Нийслэлийн төсвийн зарлагыг өмнөх оны гүйцэтгэлээс 2,472,238.4 сая төгрөг буюу 73.5 хувиар нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

1.1.1. Хотын төсөв*Хүснэгт 4. Хотын төсвийн 2025 оны өөрчлөлт, (сая төгрөгөөр)*

Үзүүлэлт	Анх баталсан (НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоол)	Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр баталсан (НИТХ-ын 2025 оны 25/132 дугаар тогтоол)	Зөрүү	
			дүн	хувь
НИЙТ ОРЛОГО	1,587,191.8	1,785,844.9	198,653.1	112.5
Төсвийн орлого	1,563,073.6	1,770,045.2	206,971.6	113.2
Татварын орлого	1,050,723.2	1,137,423.2	86,700.0	108.3
Татварын бус орлого	512,350.4	632,622.0	120,271.6	123.5
Тусламжийн орлого	24,118.2	15,799.7	(8,318.5)	65.5
НИЙТ ЗАРЛАГА	5,971,827.1	4,567,511.6	(1,404,315.5)	76.5
Урсгал зардал	1,165,475.5	1,377,741.1	212,265.6	118.2
Хөрөнгийн зардал	4,735,354.7	2,986,863.6	(1,748,491.1)	63.1
Зээлийн эргэн төлөлт	56,869.4	54,345.0	(2,524.4)	95.6

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газрын дуудлага худалдааг зохион байгуулж, өмнөх онуудын дуудлага худалдааны анхны үнийн дутууг төсөвт нөхөн төвлөрүүлэхээр тооцсоноор газрын дуудлага худалдааны орлогыг анх баталсан дүнгээс 79,500.0 сая төгрөгөөр, ХХОАТ-ын буцаан олголтын хэмнэлт 7,200.0 сая төгрөгийг бууруулахаар тооцсоноор татварын орлогын эх үүсвэр нийт дүнгээрээ 86,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Татварын бус орлогыг анх баталсан дүнгээс 120,300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан. Үүнд, өмч хувьчлалын орлогыг 50,000.0 сая төгрөгөөр, бондын эх үүсвэрээс ашиглаагүй үлдэгдлийг арилжааны банкнуудад хугацаатай хадгаламжаар байршуулснаар хүүгийн орлогоор 66,600.0 сая төгрөгийг, ЗХУТ-өөс төсөвт төвлөрүүлэх хүү торгуулийн орлогыг 5,000.0 сая төгрөгөөр төсөвт нэмж төвлөрүүлэхээр тооцсон байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн 2024 оны машин цагийн зардлыг шинэчлэн батлах тухай 26 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны машин цагийн зардлын задаргааг шинэчлэн батлах тухай А/290 дугаар захирамжаар машин цагийн тарифт өөрчлөлт оруулж 4 дүгээр сарын 1-нээс мөрдөн ажилласан. Мөн нийтийн хотын хүн амын өсөлт, суурьшлаас хамаарч автобусны үйлчилгээний шинэ чиглэлийг нэмэгдүүлсэн. Энэхүү тарифын өөрчлөлт болон чиглэл нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор нийтийн тээврийн татаасны төсвийг 50,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

НИТХ-ын 2025 оны 25/106 дугаар “Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр, арга хэмжээнд 45,000.0 сая төгрөгийг нэмж тусган санхүүжүүлсэнтэй холбоотой зардал өссөн.

Нийслэлийн 2025 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тодотголын өөрчлөлтүүд. Үүнд:

- Нийслэлийн 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэлтэй уялдуулан нийслэлийн гадаад үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 1,273,617.7 сая төгрөг, дотоод үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 27,370.0 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломж хязгаарлагдаж, батлагдсан санхүүжилтээс 749,243.0 сая төгрөгийг дараагийн төсвийн жилд буюу 2026 онд шилжүүлсэн байна.

1.1.2. Дүүргийн төсөв:

Дүүргүүдийн 2025 оны төсвийн төсөлд эх үүсвэрийг нийт 2,293,239.6 сая төгрөгөөр төлөвлөн ДИТХ-д хүргүүлснийг 172,094.0 сая төгрөгөөр буюу 7.5 хувиар нэмэгдүүлэн 2,465,333.6 сая төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1^[1]-т заасны дагуу Засгийн газрын 2024 оны 201, 264, 265 дугаар тогтоолоор үнэт цаас гаргаж, арилжаалах замаар 2,508,396.2 сая төгрөгийн орлого олохоор тооцож, эх үүсвэрийг нэмэгдүүлж (эх үүсвэрийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлж) дараах хөрөнгө оруулалтын ТАХ-г санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд: БГД төсвөө анх батлахдаа нийслэлээс хянасан дүнг 18,364.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 374,786.8 сая төгрөгөөр төсвийн орлогоо баталсан бөгөөд төсвийн тодотголоор орлогын дүнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Дүүргүүдийн 2025 оны төсвийн орлого, зарлагыг ДИТХ-ын тогтоолоор 1-3 удаа тодотгож, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 54,887.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,702,256.6 сая төгрөгөөр баталжээ.

Хүснэгт 5. Дүүргүүдийн төсөвт орсон өөрчлөлт, (сая төгрөгөөр)

^[1] 13.1 "Нийслэл хуульд заасан нөхцөл, журмын дагуу үнэт цаас гаргаж болно."

ДД	Дүүрэг	Анх баталсан		Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр		Зөрүү орлого		Зөрүү зардал	
		Орлого	Зарлага	Орлого	Зарлага	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	БЗД	381,360.0	383,350.6	379,093.1	381,001.8	(2,266.9)	99.4	(2,348.8)	99.4
2	СБД	652,466.1	720,919.7	649,789.0	722,705.1	(2,677.1)	99.6	1,785.4	100.2
3	БХД	13,791.5	13,807.1	13,749.1	15,514.3	(42.4)	99.7	1,707.2	112.4
4	СХД	187,432.0	200,216.9	185,201.9	210,831.2	(2,230.1)	98.8	10,614.3	105.3
5	НД	34,635.8	38,478.9	35,948.9	39,792.0	1,313.1	103.8	1,313.1	103.4
6	ХУД	582,319.4	601,359.5	580,800.0	608,293.5	(1,519.4)	99.7	6,934.0	101.2
7	БНД	35,011.4	39,613.5	34,654.0	42,351.1	(357.4)	99.0	2,737.6	106.9
8	ЧД	273,566.7	296,935.9	303,310.5	326,679.6	29,743.8	110.9	29,743.7	110.0
9	БГД	352,686.9	352,686.9	324,682.0	355,087.8	(28,004.9)	92.1	2,400.9	100.7
ДҮН		2,513,269.8	2,647,369.0	2,507,228.5	2,702,256.4	(6,041.3)	100.3	54,887.6	104.4

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дээрх тогтоолоор урсгал зардлыг 196,696.5 сая төгрөг, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг 13,044.7 сая төгрөг, дүүргийн төсөвт олгох санхүүжилтийг 3,671.6 сая төгрөгөөр, нийслэлийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх дүнг 130,762.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын зардлыг 1,748,491.1 сая төгрөгөөр бууруулсан байна.

1.2. Дүүргүүдэд олгох санхүүгийн дэмжлэг, дүүргүүдийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого;

Нийслэлийн төсөвт дүүргүүдийн төсвөөс 1,417,451.5 сая төгрөг (СБД 479,478.6 сая төгрөг, ХУД 398,943.9 сая төгрөг, БЗД 148,098.8 сая төгрөг, БГД 215,939.3 сая төгрөг, ЧД 166,878.2 сая төгрөг, СХД 8,112.8 сая төгрөг) төвлөрүүлэхээр, нийслэлийн төсвөөс

дүүрэгт 17,799.1 сая төгрөгийн (БХД 10,637.7 сая төгрөг, НД 4,190.3 сая төгрөг, БНД 2,971.1 сая төгрөг) санхүүгийн дэмжлэг олгохоор баталсан байна. Энэ нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх дүн 221,121.9 сая төгрөг, нийслэлийн төсвөөс дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 1,808.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

1.3. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Нийслэлийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 130,762.8 сая төгрөгөөр баталсан байна.

Дүрслэл 5. Улсын төсөвт сүүлийн 3 жилийн төвлөрүүлсэн орлого



Эх сурвалж. Нийслэлийн 2023-2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

1.4. Нийслэл, дүүргийн ОНХС-д олгох шилжүүлэг;

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 39,536.7 сая төгрөгөөр баталсан.

НИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 25/132 дугаар тогтоолоор Нийслэлийн ОНХС-д 15,799.7 сая төгрөгийг, дүүргүүдийн ОНХС-д 23,737.0 сая төгрөгийг хуваарилж баталсан байна.

1.5. Улсын төсөвт төлөх зээлийн эргэн төлөх үндсэн болон хүүгийн төлбөр.


Дамжуулан зээлийн эргэн төлөлтийн үндсэн төлбөрт 54,345.0 сая төгрөг, хүүгийн төлбөрт 18,641.3 сая төгрөг, нийт 72,986.3 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тусгасан байна.

БҮЛЭГ 2. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО 90.6 ХУВИЙН БИЕЛЭЛТТЭЙ БАЙНА.**2.1 Нийслэлийн нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг 396,918.7 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар дутуу биелүүлсэн байна.**

Тайлант онд нийслэлийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бааз суурийг өргөжүүлэх, өмнөх оны болон тайлант оны татварын өр, ногдлыг хураан барагдуулах, хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, эрх зүйн орчны хүрээнд татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоож нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх, татвар төлөгчдөд туслан зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар далд эдийн засгийг бууруулах, татварт бүрэн хамруулах чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/379 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх, төсвийн орлогын дутуу төлөлтийг барагдуулах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, төсвийн орлогын нэр төрөл бүрээр өрийн судалгааг гаргаж, барагдуулах ажлыг 9 дүүрэг, орлого бүрдүүлэгч байгууллагуудтай хамтран зохион байгуулсан;
- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/509 дүгээр захирамжаар нийслэлийн хэмжээнд газар зүйн мэдээллийн санд суурилсан татварын нэгдсэн системийг хөгжүүлэн нэвтрүүлж, “Татвар төлөгчийг танин мэдэх, зөвлөн туслах” зорилготой ажлын байр, үл хөдлөх эд хөрөнгө, газрын шинэчилсэн бүртгэл тооллогыг зохион байгуулсан;
- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/226 дугаар захирамжаар Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, авто зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөрийг хураан барагдуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, нийслэлийн замын санд төвлөрөх албан татвар, төлбөрийн орлогыг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.

Дүрслэл 6. Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 3 оноор харуулбал:



Үзүүлэлт	Төлөвлөгөө (сая төгрөг)	Гүйцэтгэл (сая төгрөг)
2023 он	2,001,627.5	2,205,040.1
2024 он	3,283,703.7	3,091,124.7
2025 он	4,222,915.5	3,825,996.8

Эх сурвалж. Нийслэлийн 2023-2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эндээс нийслэлийн төсөв 2025 онд өмнөх онуудаас өссөн боловч орлогын төлөвлөгөө тасарсан харагдаж байна.

Нийслэлийн 2025 оны төсөвт нийт 4,222,915.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3,825,996.8 сая төгрөгийг төвлөрүүлж, баталсан төлөвлөгөө 396,918.7 сая төгрөг буюу 9.4 хувиар дутуу биелсэн байна. (Хавсралт 1)

Хүснэгт 6. Нийслэлийн 2025 оны төсвийн орлого, (сая төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны				Өмнөх оноос өөрчлөлт
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
А	Б	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
	Нийт орлого	3,091,124.7	4,222,915.5	3,825,996.8	(396,918.7)	90.6	734,872.1
1	Урсгал орлого	3,043,082.1	4,183,378.8	3,786,836.2	(396,542.6)	90.5	743,754.1
1.1	Татварын орлого	2,804,984.9	3,563,968.1	3,210,667.8	(353,300.3)	90.1	405,682.9
1.2	Татварын бус орлого	238,097.2	619,410.7	576,168.4	(43,242.3)	93.0	338,071.2
2	Тусламжийн орлого	48,042.6	39,536.7	39,160.6	(376.1)	99.0	(8,882.0)
2.1	ОНХНС-гаас олгох шилжүүлэг	48,042.6	39,536.7	39,160.6	(376.1)	99.0	(8,882.0)

Эх сурвалж. Нийслэлийн 2024, 2025 онуудын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Төсвийн орлогын гүйцэтгэлийг бүтцээр нь авч үзвэл татварын орлого 83.9 хувь, татварын бус орлого 15.1 хувь, ОНХНС-ийн шилжүүлгийн орлого 1.0 хувийг бүрдүүлж байна.

Нийслэлийн татварын орлогод 3,210,667.8 сая төгрөг төвлөрч 90.1 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 7. Татварын орлогын биелэлт, (сая төгрөгөөр)

Татварын төрөл	Давсан орлого	Татварын төрөл	Тасарсан орлого
Хөрөнгийн орлого	16,748.9	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	(168,425.2)
Нийслэл хотын албан татвар	3,379.3	ААН-ийн орлогын албан татвар	(122,467.1)
Үйл ажиллагааны орлого	3,126.4	Дуудлага худалдаа	(40,976.1)
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	982.6	Газрын төлбөр	(10,818.7)
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	333.1	Шууд бус орлого	(10,602.8)
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	25.4	Улсын тэмдэгтийн хураамж	(9,711.8)
	-	Хөрөнгө борлуулсны орлого	(9,295.5)
	-	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	(3,909.8)
	-	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	(1,136.4)
	-	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	(287.5)
	-	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	(208.7)
	-	Малд ногдуулах албан татвар	(30.8)
	-	Галт зэвсгийн албан татвар	(25.5)
Дүн	24,595.7	Дүн	(377,895.9)

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 168,425.2 сая төгрөг буюу 10.7 хувь, ААНОАТ 122,467.1 сая төгрөг буюу 13.0 хувь, дуудлага худалдааны орлого 40,976.1 сая төгрөг буюу 45.8 хувиар тус тус тасарсан нь нийт тасарсан орлогын 87.8 хувийг эзэлж байна.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.17 дахь заалтын дагуу дүүргийн төсөвт төвлөрдөг бөгөөд Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүд төсвөө дүүргийн ИТХ-аар батлуулахдаа нийслэлээс хянасан дүнгээс нэмэгдүүлэн баталсан хэдий ч орлогын бүрдүүлэлтийг ханган ажиллаагүй нь энэ төрлийн татварын орлогын тасралтад голлон нөлөөлсөн байна.

Улс орны эдийн засгийн нөхцөл байдал, ААН, байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн хүндрэлээс шалтгаалан улсын төсвийн орлого тасалдаж, улсын төсвөөс нийслэлийн төсөвт хуваарилахаар төлөвлөсөн ААН-ийн орлогын албан татварын орлого 122,467.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газрын дуудлага худалдааг зохион байгуулж, өмнөх онуудын газрын дуудлага худалдааны анхны үнийг нөхөн бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэн ажилласнаар 89,500.0 сая төгрөгийг хотын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 48,542.3 сая төгрөгийг төвлөрүүлж, 40,976.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Нийслэлийн 6 нэр төрлийн татварын орлого 24,595.7 сая төгрөгөөр давж, 13 нэр төрлийн татварын орлого 377,895.9 сая төгрөгөөр дутуу биелж, нийт татварын орлого 90.1 хувийн биелэлттэй байна.

Нийслэлийн татварын бус орлогод 576,168.3 сая төгрөг төвлөрч 93.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 8. Татварын бус орлогын биелэлт, (сая төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны				Өмнөх оноос өөрчлөлт
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
А	Б	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	238,097.2	671,410.8	580,072.8	(91,338.0)	86.4	341,975.6
1	Нийтлэг татварын бус орлого	237,488.8	619,410.8	576,168.3	(43,242.5)	93.0	338,679.5
1.1	Хувьцааны ногдол ашиг	3,344.9	1,533.8	2,047.0	513.2	133.5	(1,297.9)
1.2	Хүүгийн орлого	20,942.5	265,616.9	241,520.1	(24,096.8)	90.9	220,577.6
1.3	Торгуулийн орлого	113,840.5	160,255.3	143,731.6	(16,523.7)	89.7	29,891.1
1.4	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,985.7	52,289.1	59,782.6	7,493.5	114.3	(1,203.1)
1.5	Түрээсийн орлого	3,136.5	3,068.9	2,644.2	(424.7)	86.2	(492.3)
1.6	Бусад орлого	35,238.7	136,646.8	126,442.8	(10,204.0)	92.5	91,204.1
2	Хөрөнгийн орлого	608.4	52,000.0	3,904.5	(48,095.5)	7.5	3,296.1
2.1	Өмч хувьчлалын орлого	608.4	52,000.0	3,904.5	(48,095.5)	7.5	3,296.1

Эх сурвалж. Нийслэлийн 2024, 2025 онуудын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Татварын бус орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл хүү, торгуулийн орлого 40,620.5 сая төгрөг, ангилагдаагүй бусад орлого 10,204.0 сая төгрөг, түрээсийн орлого 424.7 сая төгрөгөөр тасарч, нийслэлийн өмчит газруудаас төсөвт төвлөрүүлж буй ноогдол ашиг 513.2 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 7,493.5 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Тайлант оны төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад хүүгийн орлого огцом өссөн нь бондын эх үүсвэрээс зарцуулаагүй хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкуудад хугацаатай, хүүтэй байршуулснаар хүүгийн орлого 199,500.0 сая төгрөг, бондын эх үүсвэрээс санхүүжсэн Бөөрөлжүүтийн цахилгаан станцаас хүүгийн төлбөрт 42,020.1 сая төгрөгийг тус тус нийслэлийн төсөвт буцаан төвлөрүүлсэн нь орлогын өсөлтөд нөлөөлжээ.

Нийслэлийн гудамж талбайд замын хөдөлгөөний зөрчлийг илрүүлэх хяналтын иж бүрэн камерын системийг суурилуулж, нийслэлийн хэмжээнд 354 гэрээт цагдааг ажиллуулснаар замын хөдөлгөөний зөрчилд ногдуулж буй торгуулийн орлого өмнөх оны гүйцэтгэлээс 25,500.0 сая төгрөгөөр өссөн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.12 “Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасныг үл харгалзан өмч хувьчлалын орлогыг төсвийн орлого хэсэгт бүртгэхгүй төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр талд бүртгэнэ.” гэж заасны дагуу өмч хувьчлалын орлогыг төсвийн гүйцэтгэлийн тайланд алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тайлагнасан байна.

Нийслэлийн 2 нэр төрлийн татварын бус орлого 8,006.7 сая төгрөгөөр давж, 4 нэр төрлийн татварын бус орлого 51,249.2 сая төгрөгөөр дутуу биелж, нийт татварын бус орлого 93.0 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар ОНХНС-аас нийслэлд хуваарилах шилжүүлгийг 39,536.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 39,160.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 9. ОНХС-ийн судалгаа, (сая төгрөгөөр)

№	Нийслэл, дүүрэг	2024			2025		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Хотын шууд	20,051.7	19,202.6	(849.1)	15,799.7	15,649.4	(150.3)
2	БНД	6,706.7	6,422.6	(284.1)	5,288.4	5,238.0	(50.3)
3	БХД	592.6	567.5	(25.1)	467.1	462.7	(4.4)
4	БГД	1,599.2	1,531.5	(67.7)	1,260.1	1,248.1	(12.0)
5	БЗД	5,465.1	5,233.7	(231.4)	4,306.3	4,265.4	(41.0)
6	НД	3,790.6	3,630.1	(160.5)	2,988.9	2,960.5	(28.4)
7	СБД	1,395.0	1,335.9	(59.1)	1,099.1	1,088.6	(10.5)
8	СХД	5,377.9	5,150.2	(227.7)	4,238.0	4,197.6	(40.3)
9	ХУД	3,237.7	3,100.6	(137.1)	2,552.4	2,528.1	(24.3)
10	ЧД	1,950.5	1,867.9	(82.6)	1,536.8	1,522.2	(14.6)
	Нийт	50,167.0	48,042.6	(2,124.4)	39,536.7	39,160.6	(376.1)

Эх сурвалж. Нийслэлийн 2024, 2025 онуудын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

2.2 Хотын шуудын орлого 88.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хотын шуудын 2025 оны нийт орлогын төлөвлөгөөг 1,733,844.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,528,837.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөө 88.2 хувийн биелэлттэй байна.

Тайлант онд татварын орлого 86.9 хувь, татварын бус орлого 90.4 хувь, тусламжийн орлого 99.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 10. Хотын шуудын 2025 оны төсвийн орлогын биелэлт, (сая төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны				Өмнөх оноос өөрчлөлт
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
А	Б	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
	Нийт орлого	1,045,071.0	1,733,844.9	1,528,837.4	(205,007.5)	88.2	483,766.4
1.1	Татварын орлого	833,931.5	1,137,423.2	988,316.4	(149,106.8)	86.9	154,384.9
1.2	Татварын бус орлого	191,936.9	580,622.0	524,871.6	(55,750.4)	90.4	332,934.7
1.3	Тусламжийн орлого	19,202.6	15,799.7	15,649.4	(150.3)	99.0	(3,553.2)

Эх сурвалж. Нийслэлийн 2024, 2025 онуудын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

2025 онд нийслэлийн төсөвт татварын орлогоор 988,316.4 сая төгрөг төвлөрч, 149,108.6 сая төгрөгөөр дутуу биелсэн байна.

Хүснэгт 11. Хотын шуудын 2025 оны татварын орлогын биелэлт, (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ТАТВАРЫН ОРЛОГО	1,137,423.2	988,316.4	(149,106.8)	86.9
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	-	4,078.4	4,078.4	-
ХХОАТ-ын буцаан олголт	(52,800.0)	(52,466.9)	333.1	99.4
ААН-ийн орлогын албан татвар	940,900.0	818,432.9	(122,467.1)	87.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	3,821.8	3,821.8	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	120,273.7	121,256.3	982.6	100.8
Улсын тэмдэгтийн хураамж	-	235.6	235.6	-
Газрын төлбөр	-	1,637.6	1,637.6	-
Дуудлага худалдаа	89,500.0	48,523.9	(40,976.1)	54.2
Ойн нөөц ашигласны төлбөр	24.9	54.8	29.9	220.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4,718.1	4,556.2	(161.9)	96.6
Нийслэл хотын албан татвар	34,806.5	38,185.8	3,379.3	109.7

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу 2024 онд татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдах иргэдийн тайланг харьяа дүүргийн татварын хэлтсээр дамжуулан хүлээн авч, нийслэлийн Засаг даргын 2025 оны А/378 дугаар захирамжаар санхүүжилт олгох эрхийг нээн, Нийслэлийн Татварын газраас баталгаажиж ирсэн жагсаалтын дагуу 28188 татвар төлөгч иргэдэд 52,466.9 сая төгрөгийн буцаан олголтыг хуулийн дагуу бүрэн олгосон байна.

Нийслэлийн Татварын газарт 2022 оноос өмнө үүссэн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, газрын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын нийт 47,788.3 сая төгрөгийн өр бүртгэлтэйгээс 2024 онд 20,320.1 сая төгрөг, 2025 онд 9,537.8 сая төгрөг тус тус төлөгдөж, 17,930.3 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна.

2025 онд нийслэлийн төсөвт татварын бус орлогоор 540,520.5 сая төгрөг төвлөрч, 55,900.8 сая төгрөгөөр дутуу биелсэн байна.

Хүснэгт 12. Хотын шуудын 2025 оны татварын бус орлогын биелэлт, (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	596,421.7	540,520.9	(55,900.8)	90.6
Нийтлэг татварын бус орлого	580,622.0	524,871.5	(55,750.5)	90.4
Хувьцааны ногдол ашиг	1,533.8	2,047.0	513.2	133.5
Хүүгийн орлого	265,616.9	241,520.1	(24,096.8)	90.9
Торгуулийн орлого	127,910.0	99,752.0	(28,158.0)	78.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	48,024.1	55,293.3	7,269.2	115.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,862.9	53,051.0	8,188.1	118.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,161.2	2,242.3	(918.9)	70.9
Түрээсийн орлого	3,068.9	2,644.2	(424.7)	86.2
Бусад орлого	134,468.3	123,614.9	(10,853.4)	91.9
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	15,799.7	15,649.4	(150.3)	99.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	15,799.7	15,649.4	(150.3)	99.0

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Төсөвт байгууллагын өөрийн орлого 7,269.2 сая төгрөг буюу 15.1 хувиар давж биелсэн байна. Нийслэлийн төсөвт 35 байгууллага өөрийн орлогын төлөвлөгөөг 15,023.6 сая төгрөгөөр давуулан, 7 байгууллага 7,754.4 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. (Хавсралт 2)

2.3 Дүүргүүдийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2 дүүрэг 2.7-25.8 хувиар давуулан, 7 дүүрэг 2.9-11.6 хувиар дутуу биелүүлсэн байна.

Нийслэлийн 9 дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2,489,070.6 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2,297,159.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 92.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийслэлийн төсвийн орлогын 60.0 хувийг дүүргүүдийн төсвийн орлого бүрдүүлсэн байна.

Хүснэгт 13. Нийслэлийн дүүргүүдийн 2025 оны төсвийн орлогын биелэлт, (сая төгрөгөөр)

Дүүрэг	2024 оны гүйцэтгэл	2025 оны				Өмнөх оноос өөрчлөлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
1. БНД	29,565.0	31,682.9	32,527.1	844.2	102.7	2,962.1
2. БХД	3,418.8	3,111.4	3,907.1	795.7	125.6	488.3
3. БГД	273,032.6	324,682.0	294,019.9	(30,662.1)	90.6	20,987.3
4. БЗД	312,387.1	379,093.1	343,692.0	(35,401.1)	90.7	31,304.9
5. НД	27,158.4	31,399.8	30,500.7	(899.1)	97.1	3,342.3
6. СХД	156,571.2	185,201.9	163,794.9	(21,407.0)	88.4	7,223.7
7. СБД	538,601.4	649,789.0	619,922.1	(29,866.9)	95.4	81,320.7
8. ХУД	456,651.1	580,800.0	528,033.1	(52,766.9)	90.9	71,382.0
9. ЧД	248,668.0	303,310.5	280,762.4	(22,548.1)	92.6	32,094.4
Нийт дүн	2,046,053.6	2,489,070.6	2,297,159.3	(191,911.3)	92.3	251,105.7

Эх сурвалж. Нийслэлийн 2024, 2025 онуудын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Тайлант оны орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 27.2-7.2 хувиар өсгөж төлөвлөсөн байна.

Дүүргүүдийн төсвийн орлого тасарсан нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар 172,503.6 сая төгрөгөөр дутуу биелсэнтэй холбоотой бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг зарим эмнэлгүүдийн санхүүжилтийг бүрэн олгоогүй тул хувь хүний орлогын албан татварыг төлөөгүй өр үүсгэсэн, төсвийн орлогын тасралтаас үүдэн төсөвт байгууллагуудын санхүүжилт саатсан зэргээс шалтгаалсан байна.

Нийслэлийн Татварын газар болон харьяа дүүргийн ЗДТГ-аас дүүргүүдийн Татварын хэлтсүүдэд татварын хууль, тогтоомжийг сурталчлах, татвар хураалт, орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх, татвар төлөгчдийн өдрийг тэмдэглэх, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний орчин, нөхцөлийг сайжруулах зэрэг зориулалтаар нийт 1,962.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулсан олгосон байна.

НИТХ-ын 2025 оны 25/132 дугаар тогтоолоор дараах 6 дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт 1,417.451.4 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,344,304.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Дүүргүүдийн 2025 онд нийслэлд төвлөрүүлсэн дүнгийн судалгаа, (сая төгрөгөөр)

№	Дүүрэг	Дүүргийн төсвийн орлого			Нийслэлд төвлөрүүлсэн дүн		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	БГД	324,682.0	294,019.9	(30,662.2)	215,939.2	196,282.1	(19,657.1)
2	БЗД	379,093.1	343,692.0	(35,401.1)	148,098.8	133,291.6	(14,807.2)
3	СХД	185,201.9	163,794.9	(21,407.0)	8,112.8	8,112.8	-
4	СБД	649,789.0	619,922.1	(29,866.9)	479,478.5	479,478.5	-
5	ХУД	580,800.0	528,033.1	(52,766.9)	398,943.9	375,260.9	(23,683.0)
6	ЧД	303,310.5	280,762.4	(22,548.0)	166,878.2	151,878.2	(15,000.0)
	Нийт	2,422,876.5	2,230,224.4	(192,652.1)	1,417,451.4	1,344,304.1	(73,147.3)

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Нийслэлд төвлөрүүлэх дүнг дутуу төвлөрүүлсэн нь дүүргүүдийн төсвийн орлогын биелэлтээс шалтгаалсан байна.

Төсвийн орлоготой холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй тооцоолж батлаагүйгээс 2025 оны батлагдсан орлогын төлөвлөгөө 899.1-52,766.9 сая төгрөгөөр тасарч, төсвийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна. (НД ТТЗ, СХД ТТЗ, ЧД ТТЗ, СБД ТТЗ, БГД ТТЗ, БЗД ТТЗ, ХУД ТТЗ)
- Дүүргийн Засаг дарга зарим ОНӨААТҮГ-тай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ" байгуулаагүй, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө батлаагүй, дүүргийн 7 ОНӨААТҮГ-ын 6 нь тайлант хугацаанд алдагдалтай ажилласан байна. (НД ТТЗ)
- Төсвийн төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна. (БЗД ТТЗ, НД ТТЗ, ХУД ТТЗ, СХД ТТЗ)

БҮЛЭГ 3. ЗАРИМ ОНӨААН-ҮҮД ЭДИЙН ЗАСГИЙН ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

Нийслэлийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг нийт 52 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 45 байгууллага аж ахуйн нэгжийн, 7 байгууллага төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргаж байна.

Нийслэлийн өмчит ААНБ-үүдийн удирдах албан тушаалтнуудын сарын дундаж цалин 4,935.0 мянган төгрөг байна. Үүнээс 9 ААН-ийн удирдах албан тушаалтны сарын цалин нь дунджаас өндөр буюу 5,5 саяас 12.8 сая төгрөг байна. Үүнд: төсвөөс 100 хувь санхүүжилт авдаг, төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргадаг Бодлогын судалгаа шинжилгээний төв ОНӨТҮГ, Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ зэрэг байгууллагууд байна. (*Хавсралт 6*)

Аж ахуйн нэгжийн тайланд гаргаж буй 45 байгууллагын 24 нь ОНӨААТҮГ, 21 нь ХХК статустай үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд 3 аж ахуйн нэгж татан буугдаж, 12 аж ахуйн нэгж шинээр байгуулагдаж, 4 байгууллага үйл ажиллагааны статус өөрчлөгдсөн байна. (*Хавсралт 7*)

НЗД-ын 2025 оны А/921 дүгээр захирамжаар 19 ОНӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг 725,190.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 794,567.0 сая төгрөгийн зарцуулж, 25,846.0 сая төгрөгийн ашигтай ажиллагааар баталсан байна.

Гэрээ байгуулсан ААНБ-ууд нийт 747,707.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 760,043.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 2,635.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Дулааны цахилгаан станц тав ОНӨААТҮГ, Улаанбаатар спорт менежмент ХХК, Олон улсын худалдаа логистикийн төв ХХК, Улаанбаатар энерги ХХК, Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК, Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК, Сэлбэ хорин минутын хот корпораци ХХК, Улаанбаатар түншлэл ХХК, Улаанбаатар орон сууцжуулалт ХХК, Багахангайн үйлдвэрлэл технологийн парк ХК, Нийслэлийн орон сууцны корпораци ХК, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК зэрэг 12 аж ахуйн нэгжийн эдийн засгийн зорилтот түвшинг тухайн ААНБ-уудын ТУЗ нь баталсан байна.

Эдгээр компаниудын 2025 оны зорилтыг 110,940.7 сая төгрөгийн орлоготой, 108,593.3 сая төгрөгийн зардалтай, 2,344.0 сая төгрөгийн ашигтай ажиллагааар баталсан байна.

Гүйцэтгэлээр 111,411.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 114,363.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 1,689.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

НЗД нь 1 ОНӨААТҮГ-ын, ТУЗ нь 13 байгууллагын эдийн засгийн зорилтот түвшинг батлаагүй байна. (Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар ОНӨААТҮГ, Нийслэлийн Соёлын төв өргөө ОНӨААТҮГ, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ, Улаанбаатар хотын барилга байгууламжийн судалгаа, шинжилгээний газар ОНӨААТҮГ, Улаанбаатар смарт карт ХХК, Эрдэнэс баянбогд ХХК, Хүннү хотын хөгжлийн корпораци ХХК, Тархмал эрчим

хүчний дэд бүтэц ХХК, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ХК, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК)

Эдгээрээс КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар ОНӨААТҮГ, Нийслэлийн Соёлын төв өргөө ОНӨААТҮГ, Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК зэрэг 4 аж ахуйн нэгж төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргасан, Улаанбаатар хотын барилга байгууламжийн судалгаа, шинжилгээний газар ОНӨААТҮГ нь 2025 онд үйл ажиллагаа явуулаагүйгээс, Хүннү хотын хөгжлийн корпораци ХХК нь 2025 оны 12 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлснээс аудитад хамрагдаагүй.

Эдийн засгийн зорилтот түвшин батлуулан мөрдөж ажилласан 31 ААНБ-ын 64.5 хувь нь 25,817.8 сая төгрөгийн ашигтай, 35.5 хувь нь 41,105.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. (Хавсралт 8,9)

Зорилтот түвшнийг оновчтой төлөвлөөгүйгээс өөрийн үйл ажиллагааны үр дүнд орлого бүрдүүлж ажилладаг 14 ААНБ-ын орлого 42,649.4 сая төгрөгөөр тасарчээ. (Хавсралт 10)

НЗД-ын 2025 оны 921 дүгээр захирамжаар ашигтай ажилласан 9 орон нутгийн өмчит байгууллагын удирдлагуудад зорилтот түвшингээс давсан цэвэр ашгийн 20 хүртэл хувиар 1,657.5 сая төгрөгийн буюу хэт өндөр урамшуулал олгохоор шийдвэрлэж, алдагдалтай ажилласан 31 байгууллагын хувьд алдагдал бууруулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй боловч нийслэлийн төсвөөс 625.4 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал зарцуулсан байна. (Багахангай Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ 62.8 сая төгрөг, Хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл 61.6 сая төгрөг, Хүннү хотын хөгжлийн корпораци ХХК 417.9 сая төгрөг)

Хүнс хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг 5 байгууллага (Асгат хүнс ОНӨААТҮГ, Хүнс хангамж ОНӨААТҮГ, Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ, Багачууд хүнс ОНӨААТҮГ, Налайх хангамж ОНӨААТҮГ) нь зах зээлийн үнээс өндрөөр хүнсний бүтээгдэхүүн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагуудад нийлүүлж байгаа нь төсвийн байгууллагуудад хүндрэл учруулж, цаашлаад хоолны хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж байна. Дээрх хүнс хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын 2025 оны борлуулалтын орлогыг 32,886.2 сая төгрөг байхаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 29,865.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөө 10.1 хувиар тасарчээ.

Төсөв захирагчийн төсвийн сахилга бат хангалтгүй, хяналт сул байгаагаас төсвийг үрэлгэн зарцуулсан, албан даалгавар, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй 1,294.4 сая төгрөгийн зөрчил 18.1 хувийг эзэлж байна. /ОНӨААТҮГ/ Үүнд:

- Албан даалгавар, хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, төсвийн сахилга бат зөрчсөн. (Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 9.4 сая төгрөг, Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ 37.3 сая төгрөг, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв НӨҮГ 57.3 сая төгрөг, Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК 2.4 сая төгрөг, Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК 3.2 сая төгрөг, Улаанбаатар смарт карт ХХК 160.2 сая төгрөг, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК 0.6 сая төгрөг; Багануур үйлдвэрлэл, технологийн парк ХК 0.8 сая төгрөг, Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн

бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ 23.7 сая төгрөг, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК 1.1 сая төгрөг, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ 4.6 сая төгрөг, Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ 2.1 сая төгрөг, Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ 18.1 сая төгрөг, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ 34.6 сая төгрөг, Нийслэлийн Орон сууцны корпорац ХК 1.9 сая төгрөг, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ 193.6 сая төгрөг);

- Зардлыг зориулалт бусаар зарцуулсан.(Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ 23.4 сая төгрөг);
- Цалин, нэмэгдэл урамшууллыг хууль, журамд нийцүүлэн олгоогүй. (Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ 18.0 сая төгрөг);
- Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй.(Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ 104.6 сая төгрөг, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ 58.4 сая төгрөг, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ 9.2 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК 4.5 сая төгрөг, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ОНӨААТҮГ 4.50 сая төгрөг, Нийслэлийн хот тохижилтын газар ОНӨААТҮГ 103.1 сая төгрөг, Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ 238.9 сая төгрөг, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ 5.6 сая төгрөг);
- Өмнөх аудитын шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. (Олон улсын худалдаа логиستيкийн төв ХК 172.6 сая төгрөг)

Худалдан авах ажиллагаанд ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилт хангалтгүй, төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийгээгүй, шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулаагүй, үр ашиггүй худалдан авалтуудыг хийсэн 7,009.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /ОНӨААТҮГ/ Үүнд:

- Төсвийн захирагч нь 1,307.5 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын аргыг сонгож, хууль журамд нийцүүлэн зохион байгуулаагүй. (Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ 901.1 сая төгрөг, Замын хөдөлгөөний удирдлагын төв 406.4 сая төгрөг);
- Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршсан 688.2 сая төгрөгийн барааг цахим системээс худалдан аваагүй. (Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв НӨҮГ 61.4 сая төгрөг, Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ 195.8 сая төгрөг, Асгат хүнс ОНӨААТҮГ 11.6 сая төгрөг, Олон улсын худалдаа логиستيкийн төв ХК 159.3 сая төгрөг, Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ 260.1 сая төгрөг);
- Шаардлага хангаагүй, үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөл нь нийцээгүй нийлүүлэгчээс 1,180.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. (Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ 278.7 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК 135.1 сая төгрөг, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ 557.4 сая төгрөг, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ОНӨААТҮГ 209.5 сая төгрөг);
- Үр ашиггүй болон үндэслэлгүй 3,833.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. (Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК 878.8 сая төгрөг, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ 2,861.3 сая төгрөг, Улаанбаатар түншлэл төв ХХК 16.3 сая төгрөг, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 77.0 сая төгрөг);
- Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй.(Зорчигч тээвэр хоёр 58.4 сая төгрөг, Зорчигч тээвэр тав 9.2 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК 4.5 сая төгрөг, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ОНӨААТҮГ 4.50 сая төгрөг, Нийслэлийн хот тохижилтын газар 103.1 сая төгрөг, Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ 238.9 сая төгрөг, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ 5.6 сая төгрөг)

БҮЛЭГ 4. НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ НИЙТ ЗАРЛАГЫН 53.0 ХУВИЙГ ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ ЭЗЭЛЖ БАЙНА.

4.1 Нийт зардал төлөвлөсөн түвшинд бүрэн хүрээгүй байгаа нь хөрөнгө оруулалттай холбоотой төсөл, арга хэмжээний хэрэгжилт болон үр ашгийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 15. Нийслэлийн 2025 оны төсвийн зарлагын гүйцэтгэл, (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 он	2025 он				Өмнөх оноос өөрчлөлт
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,362,279.2	5,834,517.6	4,526,181.4	1,308,336.2	77.6	1,163,902.2
А.Урсгал зардал	1,441,301.1	2,297,268.9	2,074,976.1	222,292.7	90.3	633,675.0
Бараа ажил үйлчилгээний зардал	1,001,163.7	1,409,663.1	1,199,085.1	210,577.9	85.1	197,921.4
Хүү	61,910.3	322,457.7	321,339.5	1,118.2	99.7	259,429.2
Татаас	337,427.0	409,972.8	407,513.5	2,459.3	99.4	70,086.5
Урсгал шилжүүлэг	40,800.1	155,175.2	147,038.0	8,137.3	94.8	106,237.9
Б.Зээлийн төлбөр	109,559.0	54,345.0	54,345.0	0.0	100.0	(55,214.0)
В.Хөрөнгийн зардал	1,811,419.1	3,482,903.7	2,396,860.3	1,086,043.5	68.8	585,441.2

Эх сурвалж. Нийслэлийн 2024, 2025 онуудын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийг өмнөх оноос 1,320,511.0 сая төгрөгөөр буюу 29.3 хувиар нэмэгдүүлж баталсан байна.


Нийт зардал өмнөх оны гүйцэтгэлээс 1,163,902.2 сая төгрөгөөр буюу 34.6 хувиар өссөн нь урсгал зардал 633,675.0 сая төгрөг, хөрөнгийн зардал 585,441.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийслэлийн төсвийн 2025 оны зарлагын гүйцэтгэл нь өмнөх оны гүйцэтгэлээс өсөхөд дараах зарим зардлууд гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд:

- Улаанбаатар хот нь 2024 онд олон улсын хөрөнгийн зах зээлд 500.0 сая ам.долларын үнэт цаас гарган арилжаалж, Сэлбэ дэд төвийн гэр хорооллын дахин төлөвлөлт, иж бүрэн орон сууцжуулах төслийг 2025 оноос санхүүжүүлж 293,110.5 сая төгрөгийг олгосон;
- Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд Туулын хурдны зам төслийг 2025 онд Нийслэлийн ЗДТГ болон БНХАУ-ын “Хятадын ХаоЮОань групп” ХХК, “Тяньжин Өүбайвэй” ХХК-ын түншлэл нарын хооронд байгуулсан гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөрт 401,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон;
- Нийслэлийн төсвөөс улсын төсөвт 2025 онд 130,762.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь өмнөх оноос 111,046.3 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Улаанбаатар хотын хүн амын өсөлт, суурьшлаас хамаарч автобусны үйлчилгээний шинэ чиглэлийг нэмэгдүүлсэн, мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 26 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/290 дүгээр тушаалаар машин цагийн тарифт өөрчлөлт оруулснаар 2025 оны хувийн хэвшилд олгох татаас нь өмнөх оноос 56,449.5 сая төгрөгөөр нэмэгдсэн;

- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 133 дугаар тогтоол, НИТХ-ын 2025 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн “Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 25/106 дугаар тогтоолын дагуу агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр, арга хэмжээнд 45,000.0 сая төгрөгөөр нэмэгдсэн;


Дүрслэл 7. Нийслэлийн 2025 оны төсвийн зарлагын бүтэц, Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Нийт зардлын гүйцэтгэлийн 53.0 хувь буюу 2,396,860.3 сая төгрөгийг хөрөнгийн, 45.8 хувь буюу 2,074,976.1 сая төгрөгийг урсгал зардлын, 1.2 хувь буюу 54,345.0 сая төгрөгийг зээлийн төлбөр тус тус эзэлж байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,526,181.4 сая төгрөг буюу 77.6 хувьтай буюу урсгал зардлын төсвийг 222,292.7 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 1,086,043.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь зарим төсөл, арга хэмжээ

бүрэн хэрэгжээгүйг харуулж байна.

Дүрслэл 8.




Урсгал зардлын 554,551.5 сая төгрөг буюу 26.7 хувийг татаас, шилжүүлэгт (үүнээс 375,636.2 сая төгрөгийг нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газарт), 339,050.1 сая төгрөг буюу 16.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 321,339.5 сая төгрөг буюу 15.5 хувийг гадаад, дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр(үнэт цаасны үндсэн төлбөрт 115,526.4 сая төгрөг, үнэт цаасны хүүгийн төлбөр 187,171.7

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

сая төгрөг, дамжуулан зээлийн хүүд 18,641.4 сая төгрөг)-т, 272,373.6 сая төгрөг буюу 13.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 260,090.2 сая төгрөг буюу 12.5 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 163,480.8 сая төгрөг буюу 7.9 хувийг хангамж, бараа материалын зардалд, 101,649.3 сая төгрөг буюу 4.9 хувийг байр ашиглалтын зардалд, 62,441.1 сая төгрөг буюу 3.1 хувийг үйл ажиллагааны бусад урсгал зардалд тус тус зарцуулсан байна.

Дүрслэл 9.

Хөрөнгийн зардал, сая төг



Нийт хөрөнгийн зардлын 80.3 хувийг барилга байгууламж, 7.2 хувийг их засвар, 6.3 хувийг бусад хөрөнгө, 6.2 хувийг тоног төхөөрөмж авахад зарцуулсан байна. Нийслэлийн төсвийн 53.0 хувийг бүтээн байгуулалт, дэд бүтэц, урт хугацааны хөгжлийн төслүүдэд чиглүүлж байгаа ч байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, үр өгөөжийг оновчтой тооцож төлөвлөх, хянах шаардлага хэвээр байна.

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улаанбаатар хотын дэд бүтэц, гэр хорооллын хөгжүүлэлт, нийтийн аж ахуй болон хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр олон улсын байгууллагуудын санхүүжилттэй нийт 8 төсөл хэрэгжиж байна. Эдгээр төслийн хүрээнд дамжуулан зээлийн нийт 54,345.9 сая төгрөгийг төлсөн байна. Үүний 78.4 хувийг Азийн хөгжлийн банк, 15.1 хувийг Европын хөрөнгө оруулалтын банк, 6.5 хувийг Олон улсын хөгжлийн ассоциаци санхүүжүүлжээ. Төслүүд нь гэр хорооллын дэд бүтэц, орлогод нийцсэн орон сууц, хотын шинэчлэл, хатуу хог хаягдлын менежмент болон нийтийн аж ахуйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Дүрслэл 10. Дамжуулан төлсөн зээлийн төлбөр

Д/д	Зээлийн нэр	сая төгрөгөөр	Зээлдүүлэгч
1	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-Төсөл 1	15,539.2	ADB Азийн хөгжлийн банк
2	Хот байгуулалтын салбарын төсөл	160.0	ADB Азийн хөгжлийн банк
3	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-Төсөл 2	11,424.7	ADB Азийн хөгжлийн банк
4	“Улаанбаатар хотын орлогод нийцсэн орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”	13,773.0	ADB Азийн хөгжлийн банк
5	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-Төсөл 3	1,721.6	ADB Азийн хөгжлийн банк
6	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл	2,995.6	Европын сэргээн босголт хөгжлийн банк
7	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-Төсөл 2”	5,209.4	Европын хөрөнгө оруулалтын банк
8	УБ хотын нийтийн аж ахуйг сайжруулах төсөл	3,521.4	Олон Улсын Хөгжлийн Ассоциаци

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 16. Нийслэлийн 2025 оны төсвийн зарлагын бүтэц, (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэт- гэлийн хувь	Нийт зардалд эзлэх хувь	
					Төлөв- лөгөө	Гүйцэт- гэл
Хотын шуудын төсөв	4,549,712.5	3,538,646.4	1,011,066.1	78.2	78.0	78.2
Дүүргийн төсөв	1,284,805.1	987,535.0	297,270.1	21.8	22.0	21.8
Нийт төсөв	5,834,517.6	4,526,181.4	1,308,336.2	100.0	100.0	100.0

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хотын шуудын төсвөөс дүүргүүдийн төсөвт 17,799.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор батлагдаж, санхүүжилтийг бүрэн олгожээ. (БНД 2,971.1 сая төгрөг, БХД 10,637.7 сая төгрөг, НД 4,190.3 сая төгрөг). Өмнөх оны гүйцэтгэлээс 1,808.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсөв захирагчийн төсвийн сахилга бат хангалтгүй, хяналт сул байгаагаас төсвийг үрэлгэн зарцуулсан, албан даалгавар, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй 1,314.2 сая төгрөгийн зөрчил нь нийт зөрчлийн 18.3 хувийг эзэлж байна.

- Төсвийг үрэлгэн зарцуулж 293.8 сая төгрөгийн зардал гаргасан. (НАГ 9.4 сая төгрөг, НАОБТГ 40.5 сая төгрөг, НИТХ 19.9 сая төгрөг, ХХЗАА 5.5 сая төгрөг, НЗДТГ 218.5 сая төгрөг);
- Зардлыг зориулалт бусаар зарцуулсан. (НДАГ 52.7 сая төгрөг, НХХААГ 16.7 сая төгрөг);
- Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар хэрэгжүүлээгүй байна. (Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба 1.6 сая төгрөг, НАГ 130.0 сая төгрөг, НДАГ 39.1 сая төгрөг, ОСБГ 1.4 сая төгрөг, НАОБТГ 19.8 сая төгрөг, НАЖГ, НЗХГ 118.0 сая төгрөг, УБЗАА 441.4 сая төгрөг, ГХУСАСЗ 40.5 сая төгрөг, НЗДТГ 160.6 сая төгрөг)

Худалдан авах ажиллагаанд ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилт хангалтгүй, төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийгээгүй, шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулаагүй, үр ашиггүй худалдан авалтуудыг хийсэн 852.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Төсвийн захирагч нь 687.0 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй. (Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар 23.1 сая төгрөг, Хүүхдийн урлан бүтээх төв 25.1 сая төгрөг, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба 202.5 сая төгрөг, Монголын хүүхдийн ордон 108.3 сая төгрөг, УБЗАА 328.0 сая төгрөг);
- Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршсан 165.5 сая төгрөгийн барааг бусад этгээдээс худалдан авсан. (Улаанбаатар хотын Төв номын сан 15.9 сая төгрөг, Хот байгуулалт, хотын стандартын газар 14.6 сая төгрөг, Нийгмийн хамгааллын тусгай төв 95.7 сая төгрөг, Нийслэлийн Өмчийн харилцааны газар 39.3 сая төгрөг)

Нийслэлийн төсвөөс 2025 онд 18 ОНӨААТҮГ-т Нийслэлийн Өмчийн харилцааны газраар дамжуулан нийт 51,062.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос 29,290.0 сая төгрөгөөр буюу 134.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 17. Нийслэлийн төсвөөс ОНӨААТҮГ-уудад 2025 онд олгосон санхүүжилт, (сая төгрөгөөр)

№	САНХҮҮЖИЛТИЙН ЗОРИУЛАЛТ	ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ
1	"Улаанбаатар түншлэл" ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	2,746.1
2	Хүннү хотын хөгжлийн корпорац ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	4,000.0
3	Нийслэлийн эрсдэлийн удирдлагын сан хувийн ХОС ТЗК ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	3,000.0
4	"Хорин минутын хот корпорац" ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	3,000.0
5	"Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	3,000.0
6	"Тархмал эрчим хүчний дэд бүтцийн хөтөлбөр" ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	3,000.0
7	"Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв" НӨҮГ-ын дүрмийн сангийн хөрөнгө	3,000.0
8	Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	4,900.0
9	Багануурын үйлдвэрлэл технологийн парк ХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	700.0
10	Багахангайн үйлдвэрлэл технологийн парк ХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	700.0
11	Налайхын үйлдвэрлэл технологийн парк ХК-ийн дүрмийн сангийн хөрөнгө	800.0
Дүрмийн санд олгосон дүн		28,846.1
1	"Дулааны цахилгаан станц тав" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал	2,120.6
2	"Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал	1,516.6
3	"Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал	6,269.5
4	"КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал	1,402.8
5	Хот төлөвлөлт, судалгааны институт НӨҮГ-ын үйл ажиллагааны зардал	999.9
6	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал	9,100.0
7	"Нийслэлийн соёлын төв өргөө" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал	807.1
Үйл ажиллагааны зардалд олгосон дүн		22,216.5

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийслэлийн төсвөөс нийт 11 ХК-уудын дүрмийн сангийн хөрөнгөд нийт 28,846.1 сая төгрөг, 5 ОНӨААТҮГ-т үйл ажиллагааны зардалд нийт 22,216.5 сая төгрөгийг тус тус олгосон байна. Мөн улсын төсвийн байгууллагуудад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлуудад нийт 83,509.8 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Дүрслэл 11.



Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дүүргүүдийн төсвийн зарлагыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 110,045.3 сая төгрөг буюу 12.5 хувиар өссөн байна.

Тайлант онд дүүргүүдийн зарцуулах төсвийг 1,284,805.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 987,535.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 21.8 хувиар буюу 297,270.1 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.

ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөж ажиллаагүй, төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийгээгүй, шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулаагүй зэрэг нийт 11,053.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. (ТТЗ)

- Бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулаагүй. (СБД ТТЗ 361.5 сая төгрөг, СХД ТТЗ 1,018.1 сая төгрөг, ХУД ТТЗ 384.2 сая төгрөг, ЧД ТТЗ 4.0 сая төгрөг, БНД ТТЗ 253.5 сая төгрөг, БЗД ТТЗ 5,840.5 сая төгрөг, БГД ТТЗ 35.6 сая төгрөг)
- Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршсан 1,022.4 сая төгрөгийн барааг бусд этгээдээс худалдан авсан. (СБД ТТЗ 683.7 сая төгрөг, ЧД ТТЗ 147.2 сая төгрөг, БЗД ТТЗ 80.4 сая төгрөг, БГД ТТЗ 76.9 сая төгрөг, НД ТТЗ 34.2 сая төгрөг)
- Шаардлага хангаагүй, үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөл нь нийцээгүй нийлүүлэгчээс 2,133.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. (СБД ЗД 51.8 сая төгрөг, СХД ТТЗ 19.8 сая төгрөг, БЗД ТТЗ 2,061.6 сая төгрөг)

Төсвийн зарцуулалттай холбоотой нийт 4,553.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Төсвийг үрэлгэн зарцуулж 1,273.6 сая төгрөгийн зардал гаргасан. (БЗД 605.9 сая төгрөг, БГД 218.3 сая төгрөг, НД 75.68 сая төгрөг, СХД 110.7 сая төгрөг, СБД 67.8 сая төгрөг ХУД 80.3 сая төгрөг, ЧД 114.9 сая төгрөг)
- Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. (СБД 428.3 сая төгрөг, БНД ИТХ 7.8 сая төгрөг, БГД 620.3 сая төгрөг, БЗД 4.6 сая төгрөг, НД 3.7 сая төгрөг, СХД 793.0 сая төгрөг, ЧД 852.2 сая төгрөг,)
- Төсөвт төвлөрүүлэх 33.4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй. (БНД 33.4 сая төгрөг)
- Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийг мөрдөж ажиллаагүй. (БЗД 235.6 сая төгрөг, ХУД 18.3 сая төгрөг)

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хүрээнд нийслэл, дүүргийн ИТХ-аас төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх 56 хөтөлбөр, 97 арга хэмжээнд нийт 5,834,517.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ. (Хавсралт 11)

Өмнөх оноос нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн дараах хөтөлбөр, арга хэмжээ байна. Үүнд:

- Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 845,911.8 сая төгрөг;
- Авто замын хөтөлбөрт 140,027.1 сая төгрөг;
- Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогод 111,172.3 сая төгрөг;
- Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрт 84,685.2 сая төгрөг;
- Засгийн газрын өрийн үйлчилгээ хөтөлбөрт 73,441.1 сая төгрөг;
- Хот байгуулалт, тохижилт хөтөлбөрт 67,715.8 сая төгрөг;
- Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр хөтөлбөрт 54,969.6 сая төгрөг;
- Хөтөлбөр, төслийн удирдлага зохицуулалт хөтөлбөрт 52,695.7 сая төгрөг;
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөрт 28,134.2 сая төгрөг.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар 9 дүүргийн ТТЗ, тэдгээрийн харьяа 147 ТШЗ, нийслэлийн орон нутгийн төсвийн 28 ТШЗ, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой 52 хуулийн этгээдээс дараах судалгааг авч нэгтгэсэн. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн зөвлөлийн орон тооны болон орон тооны бус гишүүдэд 2025 онд олгосон цалин, урамшууллын судалгаанд 141 зөвлөлийн мэдээлэл хамрагдсан бөгөөд нийт 1091 гишүүн бүртгэгдсэнээс 272 нь орон тооны, 819 нь орон тооны бус гишүүн байна. Нийт зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын зардалд 1,732.0 сая төгрөг зарцуулсан байна. Судалгаагаар дээрх зөвлөлийн цалин, урамшууллын зардлын төлөвлөлт, зарцуулалт нь байгууллагуудын хувьд харилцан адилгүй, нэгдсэн шалгуургүй, зарим тохиолдолд гүйцэтгэлгүйгээр санхүүжилт олгосон нөхцөл байдал илэрч байна. Иймд зөвлөлийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан удирдлага, хяналтын тогтолцоонд шилжүүлж, төсвийн хөрөнгийн үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Нийслэл хотын 9 дүүрэгт 2025 онд 2010 хэсэг хариуцсан 2010 хэсгийн хорооны ахлагч, 2026 онд 2096 хэсэг хариуцсан 2096 хэсгийн хорооны ахлагч ажиллаж байна. Хэсгийн хорооны үйл ажиллагаа болон ахлагчийн цалин урамшуулалтай холбоотой зардлын судалгаагаар хэсгийн хорооны ахлагчийн цалин, урамшууллын дундаж 2025 оны гүйцэтгэлээр 1,081.3 мянган төгрөг, 2026 оны төсвөөр 1,280.0 мянган төгрөг байна. 2025 онд хэсгийн хорооны ахлагчийн цалин, урамшуулал, НДШ-ийн зардалд 28,281.3 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 4,581.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 8,904.8 сая төгрөгийг зарцуулжээ. 2026 онд хэсгийн хорооны ахлагчийн цалин, урамшуулал, НДШ-ийн зардалд 35,069.0 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 6,486.3 сая төгрөг, хөрөнгө оруулалтаар 2,674.7 сая төгрөгийг төсөвлөсөн байна.
- Гадаад томилолтын зардлыг өмнөх оноос 1,474.6 сая төгрөгөөр буюу 23.5 хувиар бууруулж баталсан байна. Гүйцэтгэл 1,264.6 сая төгрөгөөр буюу 24.8

хувиар буурч гадаад томилолтын зардлыг танах бодлого баримталсан байна. Гадаад томилолтын судалгаанд хамрагдсан байгууллагуудын ихэнх нь гадаад хамтын ажиллагаа, туршлага судлах чиглэлээр зардал гаргасан боловч хүрсэн үр дүнг тооцож үнэлээгүй байна. Нийслэл дүүргийн харьяа байгууллагууд гадаад томилолтын 321 арга хэмжээнд 4,789.9 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 296 арга хэмжээнд 3,838.9 сая төгрөгийг зарцуулж 951.0 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна. Үүнээс ХУД-ийн Худалдан авах ажиллагааны алба 0.24 сая төгрөг, ЧД-ийн Худалдан авах ажиллагааны алба 6.0 сая төгрөг, БЗД-ийн Дотоод аудитын алба 37.7 сая төгрөгийг гадаад томилолтод төлөвлөсөн боловч огт зарцуулаагүй байна.

- Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5-д төрийн албан хаагч орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэхээр зохицуулсан бөгөөд 29 байгууллага 269 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нэг хүнд 5.0 - 157.0 сая төгрөг олгож, нийт 5,012.0 сая төгрөг зарцуулсан байна. Нийгмийн асуудлыг шийдвэрлэх нарийвчлан зохицуулсан журамгүйгээс байгууллагууд дотоод журмын хүрээнд харилцан адилгүй шийдвэрлэж байгаа тул дараагийн аудитаар авч үзэж, эрх зүйн орчин, шалгуур үзүүлэлт, мөнгөн дүнг тодорхой болгох шаардлагатай байна.
- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/813 дугаар захирамжийг үндэслэн нийслэл, дүүргийн харьяа байгууллагуудын дарга, нягтлан бодогч, нярав зэрэг 210 санхүүгийн ажилтанд 1-3 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний балансын урамшуулал олгож нийт 762.3 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Нийслэл, дүүргийн харьяа байгууллагуудаас ажилтнуудад олгож байгаа хоол, унааны хөнгөлөлтийн судалгаа авсан бөгөөд судалгаагаар хоолны хөнгөлөлт 5.0-40.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 1.0-15.0 мянган төгрөг байгаа нь тухайн байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд харилцан адилгүй шийдвэрлэснийг харуулж байна.
- Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлтэй холбоотой 9 байгууллагын 411.7 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гарснаас тайлан онд байгууллагын төсвөөс 411.7 сая төгрөгийг олгосон байна. Үүнээс 22.3 сая төгрөгийг гэм буруутай этгээдээр төлүүлсэн, 7.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна. Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар 368.6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, албан шаардлага хүргүүлсэн байна.
- Нийслэл, дүүргийн харьяа байгууллагууд сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг 2006 удаа зохион байгуулж, 8,250.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр эрх бүхий этгээдээс баталсан тушаал, шийдвэрээр 1646 удаагийн арга хэмжээнд 7,199.6 сая төгрөг зарцуулсан байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д заасны дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилгоор нийслэл, дүүргийн харьяа 29 байгууллага 220 хэвлэл мэдээллийн байгууллагатай 0.6-80.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, нийт 2,499.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.2 Төсвийн байгууллагын батлагдсан төсөвт тусган санхүүжүүлэх боломжтой зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна.

Нэмэлт төсвөөр 228,143.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 206,878.7 сая төгрөг зарцуулж, 20,392.3 сая төгрөгийн авлага үүсгэж тайлагнасан байна.

Нэмэлт төсөв өмнөх оноос 12.5 хувь буюу 28,516.7 сая төгрөгөөр өссөн нь дараах орлогоос бүрджээ. Үүнд:

- Дээд шатны төсөв захирагчдаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 156,195.9 сая төгрөг буюу 68.5 хувь;
- ЗГНХ, ЗДНХ болон түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 31,690.0 сая төгрөг буюу 13.9 хувь;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 22,348.8 сая төгрөг буюу 9.8 хувь;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 17,908.6 сая төгрөг буюу 7.8 хувь.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 68.5 хувь буюу 156,195.9 сая төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан төсөв эзэлж байгаа нь Төсвийн ерөнхийлөн захирагчид өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилж, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг харуулбал:

- Хөрөнгө оруулалт засвар үйлчилгээ, хөрөнгө худалдан авах зардалд 58,121.0 сая төгрөг буюу 28.1 хувь;
- НӨХГ-аар дамжуулан ОНӨААН-үүдэд олгосон санхүүжилтэд 51,577.6 сая төгрөг буюу 24.9 хувь;
- Гэрэлтүүлэг, тохижилт үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт, хог хаягдал зайлуулах зардалд 22,166.9 сая төгрөг буюу 10.7 хувь;
- НЗД-ын захирамжаар үнэт цаасны шимтгэл хураамжийн төлбөрт 16,359.0 сая төгрөг буюу 7.9 хувь;
- Баянгол, Чингэлтэй дүүргүүдийн гэр хорооллын гэр, амины орон сууцны дулаалгын ажил, шингэрүүлсэн шатдаг хийн баллон түгээх цэг байгуулах ажилд 15,294.9 сая төгрөг буюу 7.4 хувь;
- Засгийн газрын 31 дүгээр тогтоолоор нөөцийн мах худалдан авч борлуулахад 13,393.1 сая төгрөг буюу 6.5 хувь;
- Нийтийн тээврийн үйлчилгээний бэлэн мөнгөний орлогыг автобус баазуудад хуваарилсан санхүүжилтэд 10,555.4 сая төгрөг буюу 5.1 хувь;
- Спорт уралдааны арга хэмжээ, сургалт сурталчилгаа, шагнал урамшуулал, гадаад томилолтын зардалд 3,420.6 сая төгрөг буюу 1.7 хувь;
- Үндэсний их баяр наадам, “Хүрээ цам - Даншиг наадам-2025” арга хэмжээнд 2,678.8 сая төгрөг буюу 1.3 хувь;
- Нийслэлийн Аялал жуулчлалын газраар дамжуулан гадаад, дотоодын аялал жуулчлалыг нэмэгдүүлэх сурталчилгааны арга хэмжээнд 2,239.6 сая төгрөг буюу 1.1 хувь;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хяналтын камер суурилуулах, тээврийн хэрэгслийн зөрчилтэй холбоотой судалгааны ажил, сургалтын үйл ажиллагаанд 2,206.3 сая төгрөг буюу 1.1 хувь;
- Хүннү хотын төлөвлөлтийн үзэл баримтлалын баримт бичиг боловсруулах олон улсын уралдаант шалгаруулалт зохион байгуулах арга хэмжээнд 2,000.0 сая төгрөг буюу 1.0 хувь;
- Агаар, орчны бохирдлын эсрэг үйл ажиллагааны зардалд 1,002.8 сая төгрөг буюу 0.5 хувь;
- Хороодын хэсгийн ахлагч нарын сургалтын зардал, иргэдийн бүлэг ажиллуулах, төрийн албаны зөвлөлөөс дөрвөн ээлжийн төрийн албаны ерөнхий шалгалт зохион байгуулах, салбар зөвлөлийн гишүүдэд ажлын

зардал, хот орчмын нийтийн тээврийн автобусны гаалийн татвар даатгалын төлбөр зэрэг бусад зардалд 5,862.7 сая төгрөг буюу 2.7 хувь.

Төсвийн байгууллагын батлагдсан төсөвт тусган санхүүжүүлэх боломжтой зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан санхүүжүүлж, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдал болон төсвийн сахилга баттай холбоотой холбогдох хууль, журмын шаардлагыг зөрчсөн байна.

Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/560 дугаар захирамжаар нийслэлийн 9 дүүрэгт нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн эвдрэл гэмтэл, засварлах ажлын зардалд хороо бүрд 50.0 сая төгрөг буюу нийт 10,200.0 сая төгрөг хуваарилсан. Үүнээс БХД нь Засаг даргын захирамжгүйгээр 93.7 сая төгрөг зарцуулсан, Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй 2,305.2 сая төгрөгийг (СХД 2,150.0 сая төгрөг, БНД 155.2 сая төгрөг) шууд гэрээ байгуулж, зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалттай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн данснаас зориуд нэр данс зөрүү гэх утгаар 172.4 сая төгрөгийн гүйлгээг гаргасан, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, өмнөх оны аудитын шийдвэрийг бүрэн биелүүлээгүй байна. (СБД-ийн ТТЗ)

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан үр ашигтай, ил тод, сахилга баттай, хариуцлагатай байх зарчмуудыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 5,105.6 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх оноос 21.5 дахин буурсан байна. Үүнд:

- Төсвийн 52 захирагч нь цахим дэлгүүрт бүртгэлгүй, худалдан авалтын захиалга хүсэлт хүргүүлээгүй, 18,915.3 сая төгрөгийн бараа материал, хөрөнгийг цахим дэлгүүрээс аваагүй;
- Төсвийн 7 захирагч нь 449.3 сая төгрөгийн бараа материал их хэмжээгээр бэлтгэж нөөцөлсөн; (НИТХ 41.6 сая төгрөг, НХХААГ 5.5 сая төгрөг, ЧД ИТХ 34.0 сая төгрөг, НДХ ЗДТГ 13.5 сая төгрөг, БГД ХЗСО 15.0 сая төгрөг, СБД ЗДТГ 304.8 сая төгрөг, СБД ИТХ 34.8 сая төгрөг)
- Гадаад албан томилолтын нислэгийг Үндэсний агаарын тээвэрлэгчээр үйлчлүүлээгүй 922.6 сая төгрөгийн зардал гаргасан (НИТХ 165.8 сая төгрөг, СБД ИТХ 48.1 сая төгрөг);
- Туршлага судлах, чадавхжуулах сургалт, семинар зохион байгуулахаар шийдвэр гаргаж гадаад томилолтын зардалд 403.3 сая төгрөг, сургалт зохион байгуулахтай холбоотой ТББ, ААНБ-тай ажил, үйлчилгээний гэрээ байгуулж 195.7 сая төгрөгийн зардал гаргаж, төсвийг үрэлгэн зарцуулсан (ХУД ЗДТГ 41.1 сая төгрөг, ХУД ИТХ 285.5 сая төгрөг, БЗД ИТХ 76.8 сая төгрөг, УБЗАА 6.0 сая төгрөг, НЗДТГ 189.7 сая төгрөг);
- Байгууллагын зардлаар спорт уралдаан тэмцээн зохион байгуулж 70.4 сая төгрөгийг хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан (СХД Захиалагчийн алба 1.7 сая төгрөг, ХУД Агро 45.4 сая төгрөг, СБД ИТХ 12.1 сая төгрөг, ОСНААУГ 4.3 сая төгрөг, УБ ЗЗАГ 4.9 сая төгрөг, Өсвөр үе хүнс 0.6 сая төгрөг, УБ Спорт менежмент 1.3 сая төгрөг);

- Санхүүгийн дэмжлэг хавтгайруулан олгож 1,440.9 сая төгрөг зарцуулсан (ЧД ИТХ 34.0 сая төгрөг, ХУД ИТХ 285.5 сая төгрөг, НИТХ 151.4 сая төгрөг, НЗДТГ 970.0 сая төгрөг);
- Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлоогүй цалин хөлсийг үр дүнтэй уялдуулж олгоогүй, урамшууллыг хавтгайруулан 570.6 сая төгрөгийн олгосон (ЧД ИТХ 6.6 сая төгрөг, УБ түншлэл төв ХХК 21.3 сая төгрөг, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 16.3 сая төгрөг, НИТХ 151.4 сая төгрөг, Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ 0.6 сая төгрөг, Асгат хүнс ОНӨААТҮГ 18.4 сая төгрөг, НЗДТГ 177.8 сая төгрөг, Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн ОНӨААТҮГ 47.5 сая төгрөг, ОСНААУГ 53.8 сая төгрөг, Олон улсын худалдаа логистикийн төв ХК 76.9 сая төгрөг,)

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн 5,105.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 38.1 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 4,374.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 30 албан шаардлага хүргүүлж, 693.4 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна.

4.4 Аудитад хамрагдсан байгууллагуудын төрийн санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй зөрчил нь өмнөх оноос 35,070.6 сая төгрөг буюу 8.0 хувиар буурсан байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийн 87.0 хувийг бүрэн байршуулж, 13.0 хувийг байршуулаагүй, нийт мэдээллийн 75.5 хувийг хуулийн хугацаанд, 24.5 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Аудитад Нийслэл, дүүргийн төсвийн 30 шууд захирагч, 58 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 2 орон нутгийн тусгай сан, нийт 97 байгууллагыг хамрууллаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 401,057.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нийт 98,618.8 сая төгрөгийн 124 мэдээллийг ил тод мэдээлээгүй;
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 78,048.0 сая төгрөгийн 507 гүйлгээг 27 байгууллага мэдээлээгүй, 182,122.1 сая төгрөгийн 1183 гүйлгээг 51 байгууллага хугацаа хоцроосон;
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 38,940.3 сая төгрөгийн 795 гүйлгээг 26 байгууллага мэдээлээгүй, 79,060.0 сая төгрөгийн 1615 гүйлгээг 52 байгууллага хугацаа хоцроосон;
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 7,475.2 сая төгрөгийн 559 шийдвэрийг 23 байгууллага мэдээлээгүй, 17,442.1 сая төгрөгийн 1306 шийдвэрийг 55 байгууллага хугацаа хоцроосон.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг 58 байгууллагад, зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг 19 байгууллагад, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай албан шаардлагыг 2 байгууллагад тус тус хүргүүлсэн байна.

Шилэн дансны цахим хуудаст зардлын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан

авах ажиллагааны тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт зэрэг 8 мэдээллийг байршуулаагүй, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хугацаа хоцроож байршуулсан, 1-8 дугаар саруудад эхний 9 сарын мэдээллийг байршуулсан, мэдээлсэн дүн хуулганы дүнгээс зөрсөн, аудитын явцад Нийслэлийн Засаг даргын гаргасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг ирүүлээгүй тул мэдээлбэл зохих дүнтэй тулгах боломжгүй байна. /ТЭЗ/ Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээг мэдээлээгүй болон хугацаа хоцроож байршуулсан байна. (Ногоон-Улаанбаатар орон сууц төслийн нэгж 166.5 сая төгрөг, Хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төслийн нэгж 101.0 сая төгрөг)

**БҮЛЭГ 5. НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ ӨМНӨХ ОНООС
32.3 ХУВИАР ӨССӨН БАЙНА.**

5.1 Улсын төсвийн 2025 оны хөрөнгөөр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа 28 төсөл, арга хэмжээний 86,513.3 сая төгрөгийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж Сангийн яаманд албан бичгээр болон улсын хөрөнгө оруулалтын цахим системээр уламжлан шийдвэрлүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар батлагдсан ТАХ-ээс 7 ТЕЗ-д хамаарах 362,741.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 55 ТАХ-г хэрэгжүүлэхээр Нийслэлийн ЗД-д эрх шилжүүлснээс 28 ТАХ-ний гэрээ байгуулж, 86,513.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Нийслэлийн ЗД-д эрх шилжүүлсэн 55,134.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 25,630.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 14 ТАХ нь шинэ, 303,247.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 40 ТАХ он дамжин шилжих ажил, 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ тодотголоор хасагдсан байна.

Нийслэлд эрх шилжсэн 55 ТАХ-ээс 18 ТАХ буюу 32.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 32 ТАХ буюу 58.2 хувь нь он дамжин хэрэгжиж, 4 ТАХ буюу 7.3 хувь нь хэрэгжиж эхлээгүй, 1 ТАХ буюу 1.8 хувь нь тодотголоор хасагдсан байна.

5.2 Нийслэлийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, хугацаа дууссан барьцааг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Хөрөнгийн зардалд 3,482,903.7 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,396,860.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 68.8 хувийн гүйцэтгэлтэй байна.


Хүснэгт 18. Нийслэлийн 2025 төсвийн хөрөнгө оруулалтын зардал, (сая төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	2024 оны гүйц	2025 оны				Өмнөх оноос өөрчлөлт
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	Б	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
Хөрөнгийн зардал		1,811,419.1	3,482,903.7	2,396,860.2	(1,086,043.5)	68.8	585,441.1
1	Барилга байгууламж	1,089,529.4	2,677,135.9	1,925,420.1	(751,715.8)	71.9	835,890.7
2	Их засвар	164,291.6	269,654.8	172,015.2	(97,639.6)	63.8	7,723.6
3	Тоног төхөөрөмж	84,954.2	224,058.0	149,373.8	(74,684.2)	66.7	64,419.6
4	Бусад хөрөнгө	472,643.9	312,055.0	150,051.1	(162,003.9)	48.1	(322,592.8)

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөрөнгийн зардалд нийт 3,482,903.7 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,396,860.3 сая төгрөгийг санхүүжүүлж, 68.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Тайлант хугацаанд хөрөнгийн зардлыг 1,086,043.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан нь голлон нөлөөлжээ. Үүний улмаас батлагдсан санхүүжилтийн 749,243.0 сая төгрөгийг дараагийн төсвийн жил болох 2026 он руу шилжүүлсэн байна. Мөн Нийслэлийн 2025 оны төсвийн тодотголоор гэрээ байгуулагдаагүй, хэрэгжих боломжгүй гэж үзсэн 18 төсөл, арга хэмжээний 104,628.5 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан нь хөрөнгийн зардлын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Дүрслэл 12. Хөрөнгийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 3 оноор харуулбал:



Эх сурвалж. Нийслэлийн 2023-2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөрөнгийн зардлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийн үзүүлэлтийг авч үзвэл жил бүр төсвийн хэмжээ нэмэгдсэн боловч гүйцэтгэлийн түвшин төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хооронд ихээхэн зөрүүтэй байдал үргэлжилж байгаа нь төсвийн үр ашиг буурах, төслүүд хугацаандаа хэрэгжихгүй байх, хөрөнгийн ашиглалтын үр дүн алдагдах эрсдэлтэй тул төлөвлөлт, хэрэгжилтийн менежментийг сайжруулах шаардлагатай байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалт: НИТХ-ын 2024 оны “Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай” 24/33 дугаар тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын ТАХ-ний эх үүсвэрт 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулжээ. Үүнд он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 206 ТАХ-нд 395,330.0 сая төгрөг, 2025 онд хэрэгжих 234 ТАХ-нд 2,374,439.8 сая төгрөг, нийслэлийн авто замын сангийн хөрөнгө оруулалтын 43 ТАХ-нд 156,293.3 сая төгрөг нийт 2,955,473.3 сая төгрөгийн 483 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 19. НИТХ-ын хөрөнгө оруулалт баталсан тогтоолын өөрчлөлт, (сая төгрөгөөр)

№	Нийт эх үүсвэр	НИТХ-ын тогтоолын огноо, дугаар		Өөрчлөлт
		2024 оны 24/33	2025 оны 25/132	
1	Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	1,566,892.0	1,687,889.9	120,997.9
2	Авто замын сангийн хөрөнгө оруулалт	153,293.3	156,293.3	3,000.0
3	2024-2025 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	757,850.4	395,330.0	(362,520.4)
4	Үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	2,188,200.0	686,549.9	(1,501,650.1)
5	Тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	29,410.2	29,410.2	-
Нийт дүн		4,695,645.9	2,955,473.3	(1,740,172.6)

Эх сурвалж. НИТХ-ын тогтоол

Дээрх хүснэгтээс харахад төсөв баталсан анхны тогтоолоос 1,740,172.6 сая төгрөг буюу 37.1 хувиар хөрөнгө оруулалтын зардал буурсан байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 2025 онд санхүүжих 234 ТАХ-ний санхүүжилтэд 2,374,439.8 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,727,680.5 сая төгрөг олгосон байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024-2025 он дамжин санхүүжих 206 ТАХ-ний санхүүжилтэд 395,330.0 сая төгрөг төлөвлөснөөс

гүйцэтгэлээр 202,823.8 сая төгрөг тус тус олгосноос, гүйцэтгэгч байгууллагад 1,876,432.4 сая төгрөг, техник хяналт, нормчлолын сангийн зардалд 14,191.2 сая төгрөг, барьцаа дансанд 26,298.8 сая төгрөг, 194.0 сая төгрөгийн алданги тооцож нийт 1,930,504.3 сая төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна.

Нийслэлийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд санхүүжих 43 ТАХ-ний санхүүжилтэд 156,293.3 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 109,878.4 сая төгрөг олгосон байна.

Нийслэлийн ЗДТГ болон БНХАУ-ын “Хао Юань Групп” ХХК, “Тяньжин ӨүБайВэй” ХХК-иудын түншлэлтэй байгуулсан “Туулын хурдны зам” барих НХААГ/20250101139 дугаар бүхий ажил гүйцэтгэх гэрээний 2,345,049.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн 500,000.0 сая төгрөгөөс тайлант онд 401,000.0 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тус мега төслийн үйл ажиллагаа зогссон байна.

Нийслэлийн ОНХС: Төсөвт өөрчлөлт оруулж он дамжин хэрэгжих 57 ТАХ-ний нийт 15,590.7 сая төгрөг, 2025 онд хэрэгжих 2 ТАХ-ний 15,799.7 сая төгрөг, нийт 31,238.4 сая төгрөгийн 59 ТАХ-г ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан байна.

Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад ТАХ-ний нэрийг “Бусад” гэсэн ерөнхий ангиллын хүрээнд 4,118.2 сая төгрөгөөр, мөн он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад “Бусад” гэсэн ерөнхий нэрийн дор 5,666.0 сая төгрөг, “Бүтээн байгуулалт, тохижилтын ажил, хөрөнгө оруулалт” гэсэн ерөнхий ангиллын хүрээнд 4,084.2 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Хүснэгт 20. НИТХ-ын ОНХС баталсан тогтоолын өөрчлөлт, (сая төгрөгөөр)

№	Нийт эх үүсвэр	НИТХ-ын тогтоолын огноо, дугаар		Өөрчлөлт
		2024 оны 24/33	2025 оны 25/132	
1	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	24,118.2	15,799.7	(8,318.5)
2	ОНХС-ийн хөрөнгөөр 2024-2025 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	15,590.7	15,590.7	-
	Нийт дүн	39,708.9	31,390.4	(8,318.5)

Эх сурвалж. НИТХ-ын тогтоол

Дээрх хүснэгтээс харахад төсөв баталсан анхны тогтоолоос 34.5 хувиар буюу 8,318.5 сая төгрөгөөр буурсан байна. ОНХС-ийн хөрөнгөөр тухайн онд санхүүжих 18 ТАХ-нд 8,210.6 сая төгрөг, он дамжин хэрэгжих 76 ТАХ-нд 9,113.6 сая төгрөг, нийт 17,324.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Хөрөнгө оруулалтын 2,690.0 сая төгрөгийн барьцааны өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй /НЗХГ 2,138.3 сая төгрөг, НХОГ 543.8 сая төгрөг, ОСНААУГ 7.9 сая төгрөг/, хугацаа дууссан 380.4 сая төгрөгийн барьцааг төсөвт төвлөрүүлээгүй /НХОГ 129.2 сая төгрөг, УБЗАА 251.2 сая төгрөг/ зэрэг зөрчил давтан гарсан байна.

Өмнөх оны аудитаар илэрч байсан асуудлууд дахин давтагдсан байгаагаас үзэхэд аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, дотоод хяналтын тогтолцоо сул, санхүүгийн сахилга хариуцлага шаардлагатай түвшинд хүрээгүй байгааг харуулж байна.

5.3 Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар улсын төсвийн байгууллагад хөрөнгө бэлтгэсэн, хугацаа дууссан барьцааг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Дүүргийн хөрөнгө оруулалт: Нийслэлийн 9 дүүргийн хөрөнгө оруулалтын нийт 689 ТАХ-ний санхүүжилтэд 435,756.1 сая төгрөг баталж, нэмэлт тодотголоор 647 ТАХ-г 278,523.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр өөрчилсөн байна.

Хүснэгт 21. ДИТХ-ын хөрөнгө оруулалт баталсан тогтоолын өөрчлөлт, (сая төгрөгөөр)

№	Дүүргийн нэр	Тодотгол хийсэн тоо	Анхны тогтоол		Нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоол		Гүйцэтгэл	
			ТАХ-ний тоо	Дүн	ТАХ-ний тоо	Дүн	ТАХ-ний тоо	Дүн
1	БНД	2	26	3,819.1	54	8,269.1	20	3,617.2
2	БХД	2	5	77,000.0	9	1,054.8	13	1,257.6
3	БГД	2	59	42,274.2	64	45,728.4	54	31,215.9
4	БЗД	3	78	51,213.4	78	51,213.4	62	32,237.0
5	НД	3	18	1,474.8	21	1,329.8	17	1,082.1
6	СХД	2	64	32,276.2	90	43,352.6	51	30,692.0
7	СБД	1	137	118,697.4	137	118,697.4	98	67,009.7
8	ХУД	1	120	66,335.6	118	66,335.6	115	35,588.4
9	ЧД	2	182	42,665.5	213	61,239.7	131	26,637.2
Нийт		18	689	435,756.1	647	278,523.4	561	229,337.2

Эх сурвалж. ДИТХ-ын тогтоол

Гүйцэтгэлээр 561 хөрөнгө оруулалтын ТАХ-нд 229,337.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Нийслэлийн 9 дүүргийн хөрөнгө оруулалтын ажлын нийт төсөв 67,009.7 сая төгрөг, үүний 29.2 хувийг СБД эзэлж байгаа нь тус дүүрэгт хөрөнгө оруулалтын төвлөрөл харьцангуй өндөр байгааг илтгэж байна. Хөрөнгө оруулалтын хуваарилалт, үр өгөөжийн тэнцвэрт байдлыг анхаарч, төлөвлөлтийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дүүргийн ОНХС: Нийслэлийн 9 дүүргийн ОНХС-ийн нийт 190 ТАХ-ний санхүүжилтэд 44,933.5 сая төгрөг баталж, нэмэлт тодотголоор 154 ТАХ-г 32,697.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр өөрчилсөн байна.

Хүснэгт 22. ДИТХ-ын ОНХС баталсан тогтоолын өөрчлөлт, (сая төгрөгөөр)

№	Дүүргийн нэр	Тодотгол хийсэн тоо	Анхны тогтоол		Нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоол		Гүйцэтгэл	
			ТАХ-ний тоо	Дүн	ТАХ-ний тоо	Дүн	ТАХ-ний тоо	Дүн
1	БНД	2	21	8,964.1	17	6,131.4	14	4,893.0
2	БХД	2	5	741.0	6	745.6	5	500.2
3	БГД	2	6	1,923.5	7	1,624.2	7	1,296.6
4	БЗД	3	38	8,563.8	32	6,215.0	27	5,108.1
5	НД	3	24	4,959.3	23	3,390.6	20	2,707.7
6	СХД	2	53	8,205.1	36	6,383.3	34	4,936.4
7	СБД	1	4	1,219.7	4	1,219.7	3	1,123.8
8	ХУД	1	22	6,197.2	18	4,856.4	18	2,208.3
9	ЧД	2	17	4,159.9	15	3,350.8	12	2,127.8
Нийт		18	190	44,933.5	154	32,697.2	140	24,901.8

Эх сурвалж. ДИТХ-ын тогтоол

Гүйцэтгэлээр 140 ТАХ-нд 24,901.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр улсын төсвийн байгууллагад 1,416.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн /БЗД 159.6 сая төгрөг, БГД ТТЗ 310.0 сая төгрөг, ЧД ТТЗ 852.2 сая төгрөг, ХУД ТТЗ 94.3 сая төгрөг/, хугацаа дууссан 183.4 сая төгрөгийн барьцааг төсөвт төвлөрүүлээгүй /ЧД ТТЗ 8.8 сая төгрөг, СБД ТТЗ 161.2 сая төгрөг, СХД ТТЗ 13.4 сая төгрөг/, хөрөнгө оруулалтын 98.2 сая төгрөгийн барьцааны өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй /БГД ТТЗ 80.1 сая төгрөг, ХУД ТТЗ 18.1 сая төгрөг/, хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,272.6 сая төгрөгийн хөрөнгийг орлогод аваагүй, нэр төрөл, тоо хэмжээг алдаатай бүртгэсэн /БЗД ТТЗ-1,829.0 сая төгрөг, ЗДТГ-443.6 сая төгрөг/, ОНХС-ийн хөрөнгийг тогтоол зөрчин, зориулалт бусаар зарцуулсан /СХД ТТЗ 788.6 сая төгрөг/ зэрэг зөрчил давтан гарч байна.

Өмнөх оны аудитаар илэрч байсан асуудлууд дахин давтагдсан байгаагаас үзэхэд өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, дотоод хяналтын тогтолцоо сул, санхүүгийн сахилга хариуцлага шаардлагатай түвшинд хүрээгүй байгааг харуулж байна.

Дүүргийн хөрөнгө оруулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Дүүргийн 2 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээлсэн байтал 2024 онд төсөвт өртгийн 59.0 хувийг олгосон. (СБД ТТЗ - 3,397.7 сая төгрөг)
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд батлагдаж, гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлын ТЭЗҮ-г 2025 оны 6 дугаар сард бүртгэж авсан. (НД ТТЗ - 20.0 сая төгрөг)
- 2025 оны дүүргийн хөрөнгө оруулалтаар анх 42,665.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөснийг 61,239.7 сая төгрөг болгож тодотгосон, гүйцэтгэлээр 26,637.2 сая төгрөг зарцуулсан нь хөрөнгө оруулалтын ажлыг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүй байна. (ЧД ТТЗ)
- Дүүргийн хөрөнгө оруулалтын бусад нөөц хөрөнгөд 2018 оноос хойших үүссэн /4,783.7 сая төгрөг/-ийн барилга, нийтийн эзэмшлийн зам талбай, тоног төхөөрөмж, автомашин, зураг төслийн ажлууд, ОНХС-ийн бусад хангамжийн материалд 2020 онд үүссэн /209.3 сая төгрөг/-ийн зураг төслийн ажлуудыг тайлант онд хийгдсэн төсөл, арга хэмжээний ажлын төлөвлөлтөд оруулах, бүрэн дууссан холбогдох байгууллагууд руу нь шилжүүлэх арга хэмжээ аваагүй байна. (ЧД ТТЗ)
- ОНХС-ийн хөрөнгөөр төсвийн хүрээнд хийгдэх батлагдсан ажлаас гадна 2 ажил хийгдсэн байна. (ЧД ТТЗ - 114.8 сая төгрөг)
- Хөрөнгө оруулалтын үр өгөөж, эдийн засгийн ач холбогдол, нэн шаардлагатай эсэхийг тооцохгүйгээр их хэмжээтэй компьютер, принтер 789,897.0 мянган төгрөг, сүү боловсруулах, зайрмаг хийх тоног төхөөрөмж 137,100.0 мянган төгрөг нийт 926,997.0 мянган төгрөгийн хөрөнгө авч, үрэлгэн зарцуулсан байна. (БЗД ТТЗ)
- Дүүргийн дотоод аудитын алба нь Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, дэмжих төвийн үйл ажиллагаа ОНХС болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай давхацсан, хөрөнгийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, хэрэгжилтийн явцад хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй, ажлын тайланд дүн шинжилгээ хийж, үр дүнг хэлэлцээгүй байна. (БЗД ТТЗ)

БҮЛЭГ 6. НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Нийслэлийн 2025 оны төсвийн урсгал тэнцэл 1,886,109.9 сая төгрөгийн ашигтай, төсвийн нийт тэнцлийг 1,611,602.1 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөж, алдагдлыг урьд оны үлдэгдлээр санхүүжүүлэхээр баталжээ.

Төсвийн гүйцэтгэлээр нийт тэнцлийн 700,184.6 сая төгрөгийн алдагдал нь урьд оны санхүүжүүлэх эх үүсвэрийн үлдэгдлээс хэтрээгүй байна.

Хүснэгт 23. Нийслэлийн нэгдсэн төсвийн тэнцэл, (сая төгрөгөөр)

Орлого, зарлагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО	4,222,915.5	3,825,996.8
Урсгал орлого	4,183,378.8	3,786,836.2
Татварын орлого	3,563,968.1	3,210,667.8
Татварын бус орлого	619,410.7	576,168.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,536.7	39,160.6
ОНХНС-аас олгох шилжүүлсэн орлого	39,536.7	39,160.6
НИЙТ ЗАРЛАГА	5,834,517.6	4,526,181.4
Урсгал зардал	2,297,268.9	2,074,976.1
Хөрөнгийн зардал	3,482,903.7	2,396,860.3
Зээлийн эргэн төлөлт	54,345.0	54,345.0
УРСГАЛ ТЭНЦЭЛ	1,886,109.9	1,711,860.1
НИЙТ ТЭНЦЭЛ	(1,611,602.1)	(700,184.6)
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР	1,611,602.1	700,184.6
Урьд оны үлдэгдэл	1,611,602.1	

Эх сурвалж. Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

БҮЛЭГ 7. ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ 70.5 ХУВЬТАЙ БАЙНА

Нийслэлийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад 1, Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 5, нийт 6 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аудитын зөвлөмжийн биелэлтийг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга албан бичгээр ирүүлээгүй, Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч 2025 оны 05-03/3290 дүгээр албан бичгээр НТАГ-т ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг аудитаар хянахад 70.5 хувийн хэрэгжилттэй байна. Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлсэн 5 зөвлөмжөөс 1 зөвлөмж бүрэн хэрэгжсэн, 3 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны аудитаар Нийслэлийн ИТХ-ын даргад өгсөн “Нийслэлийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг нарийвчилсан тооцоо судалгаа, бодит гүйцэтгэлд тулгуурлан хянаж, батлах”, Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчид өгсөн “Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т заасан үүргийг хэрэгжүүлэх, нөхөн олговрыг гэм буруутай шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаар төлүүлэх, арга хэмжээ авч ажиллах” зөвлөмжийг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Төрд учруулсан хохирлыг төлүүлэх 1,069.9 сая төгрөгийн хуримтлагдсан авлага үүссэнийг барагдуулах албан шаардлага өгсөн талаар төрийн аудитын байгууллагад

бүртгэлтэй байгаа боловч хариуцсан албан тушаалтан аудит хийхэд шаардагдах тулган баталгаажуулах мэдээллийг ирүүлээгүй байна.

Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн зөвлөлийн орон тооны болон орон тооны бус гишүүдэд төсвөөс харилцан адилгүй, нэгдсэн шалгуургүй, зарим тохиолдолд гүйцэтгэлгүйгээр цалин, урамшуулал олгосон асуудлыг;
- Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх нарийвчлан зохицуулсан журамгүйгээс байгууллагууд дотоод журмын хүрээнд харилцан адилгүй шийдвэрлэж байгаа асуудлыг;
- Улсын төсвийн байгууллагын төсөвт тусгаж төлөвлөх боломжтой зардлыг орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг олгож байгаа асуудлыг дараагийн шатны аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ

Нийслэлийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Нийслэлийн төсөвт 4 удаа тодотгол хийсэн нь төсвийн төлөвлөлтийн үр нөлөөг бууруулж, төсвийн тогтвортой байдлын зарчим алдагдаж байна.
- Нийслэлийн 2025 оны төсөвт нийт 4,222,915.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3,825,996.8 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 396,918.7 сая төгрөг буюу 9.4 хувиар дутуу биелүүлсэн байна.
- Орлогын төлөвлөгөөг 2 дүүргийн Засаг дарга (БНД, БХД) 2.4-5.8 хувиар буюу 795.8-844.2 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 7 дүүргийн Засаг дарга (НД, СХД, ЧД, СБД, БГД, БЗД, ХУД) 2.5-11.6 хувиар буюу 899.1-52,766.9 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.
- Нийслэлийн нэгдсэн төсвийн 2025 оны нийт зарлагын 53.0 хувийг хөрөнгийн зардал эзэлж, төлөвлөсөн түвшинд хүрээгүй нь хөрөнгө оруулалттай холбоотой зарим төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэнтэй холбоотой байна.
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөвт тусган санхүүжүүлэх боломжтой зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан үр ашигтай, ил тод, сахилга баттай, хариуцлагатай байх зарчмуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 35,070.6 сая төгрөг буюу 8.0 хувиар буурсан боловч төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээлбэл зохих 8 мэдээллийг байршуулаагүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж 70.5 хувийн хэрэгжилттэй байна.
- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэл, гэмтлийг засварлах ажлын хүрээнд зарим дүүрэг төсвийн хөрөнгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр зарцуулсан, мөн худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулаагүй байна.
- Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг бодит хэрэгцээ, шаардлагад тулгуурлаагүй, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил хэрэгжүүлсэн, өмнөх онуудын хэрэгжээгүй төслүүдийг бүрэн шийдвэрлээгүй, дотоод хяналтын тогтолцоо сул байна.
- Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын барьцаа дансны өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа дууссан барьцааг төсөвт төвлөрүүлээгүй, хөрөнгө оруулалтын зардлаар улсын төсвийн байгууллагад хөрөнгө бэлтгэсэн зэрэг зөрчил давтан гарсан байна.
- Эдийн засгийн зорилтот түвшинг батлуулан мөрдөж ажилласан 31 ААН, байгууллагын 64.5 хувь нь 25,817.8 сая төгрөгийн ашигтай, 35.5 хувь нь 41,105.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- Нийслэлийн өмчит 52 аж ахуйн нэгж байгууллагаас 7 нь өөрийгөө санхүүжүүлээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргаж холбогдох хуульд нийцээгүй, Бодлогын судалгаа шинжилгээний төв болон Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-ын удирдах албан тушаалтнуудын сарын дундаж цалин дунджаас өндөр буюу 6.2 -12.8 сая төгрөг байна.
- Хүнс хангамжийн үйлчилгээ эрхэлж байгаа 5 орон нутгийн өмчит хуулийн этгээд нь нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүний үнийг зах зээлийн үнээс хэт өндрөөр тогтоон төсвийн байгууллагуудад нийлүүлж байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.
- Налайх, Багануур, Багахангайн үйлдвэрлэл технологийн парк ХК-ууд, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК зэрэг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар

арга хэмжээ авалгүйгээр үйл ажиллагааны зардалд төсвөөс 5,798.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн нь төсвийн зардал нэмэгдэх, үр ашиггүй зардал гарах эрсдэлийг үүсгэж байна.

- Төрд учруулсан 1,069.9 сая төгрөгийн хохирлыг төлүүлэх хуримтлагдсан авлага үүсч ТАБ-аас барагдуулах албан шаардлага хүргүүлсэн боловч аудитын явцад хариуцсан албан тушаалтан тулган баталгаажуулах мэдээллийг ирүүлээгүй байна.
- НЗД-ын 2025 оны 921 дүгээр захирамжаар ашигтай ажилласан 9 орон нутгийн өмчит байгууллагын удирдлагуудад зорилтот түвшингээс давсан цэвэр ашгийн 20 хүртэл хувиар буюу хэт өндөр урамшуулал олгохоор шийдвэрлэж, алдагдалтай ажилласан 31 байгууллагын хувьд алдагдал бууруулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нийслэлийн ИТХ-ын даргад:

1. Нийслэлийн хөрөнгө оруулалтын төсвийг “Бусад”, “Бүтээн байгуулалт, тохижилтын ажил, хөрөнгө оруулалт” зэрэг ерөнхий нэршлээр батлахгүй байх, нийслэлийн бүтээн байгуулалттай холбоотой мега төслүүдийн явцын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж, төслийн үр дүнг хэлэлцэх;
2. Ашиг, алдагдалтай ажилласан орон нутгийн өмчит байгууллагын удирдлагуудад урамшуулал, хариуцлага тооцох зэрэг асуудлыг зохицуулж буй НИТХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолыг өөрчлөн шинэчлэх;
3. Хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээс хэт өндрөөр нийлүүлж, өөртөө давуу байдлыг бий болгож байгаа хүнс хангамжийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудыг татан буулгах арга хэмжээ авах;
4. Үйл ажиллагаа зогссон болон үйл ажиллагаа явуулж эхлээгүй орон нутгийн өмчит байгууллагуудад төсвөөс санхүүжилт олгохоор батлахгүй байх.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчд:

1. Нийслэлийн төсөвт тодотгол хийх санал оруулахдаа олон нийтийн оролцоог хангах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, ашигласан тоон мэдээлэл, судалгаа, аргачлал нь олон нийтэд нээлттэй, ил тод байж, санал өгөх боломжоор хангах;
2. Төсвийн орлого төлөвлөлтөд тавих хяналтыг сайжруулж, нийслэл, дүүргийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж ажиллах;
3. Улсын төсвийн байгууллагуудад олгох санхүүгийн дэмжлэгийг холбогдох шатны төсвөөс нь бүрэн санхүүжүүлэх зарчмыг мөрдөж, нийслэлийн төсвөөс давхардсан санхүүжилт олгохгүй байх;
4. Хороодын нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн ажлыг бодит хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөж, төсвийн хуваарилалтыг оновчтой хийж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах;
5. Нийслэлийн тайланд нэгтгэгддэг орон нутгийн өмчит байгууллагуудын эдийн засгийн зорилтот түвшинг батлах, хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх ажиллагаанд нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;
6. ОНӨААТҮГ болон ХХК, ХК-уудын эдийн засгийн зорилтот түвшнийг оновчтой тодорхойлж, алдагдлыг бууруулах;
7. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь олон нийтэд ил тод, бүрэн мэдээлэх;
8. Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-д заасны дагуу төрд учруулсан 1,069.9 сая төгрөгийг гэм буруутай этгээдээр төлүүлэх үүргийг ТЕЗ-ийн дотоод аудитын нэгж хэрэгжүүлэх, төрийг хохиролгүй болгох арга хэмжээг үе шаттай авах.

ХАВСРАЛТ**Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл, (сая төгрөгөөр)**

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд нийслэлийн төсөвт нийт 4 удаа тодотгол хийсэн нь төсвийн тогтвортой байдлын үндсэн зорилт, үзэл баримтлал алдагдах эрсдэл үүсгэж байна.	1		1	
2	Нийслэлийн 2025 оны төсөвт нийт 4,222,915.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3,825,996.8 сая төгрөгийг төвлөрүүлж, баталсан төлөвлөгөө 396,918.7 сая төгрөг буюу 9.4 хувиар дутуу биелсэн байна. Орлогын төлөвлөгөөг 2 дүүрэг (БНД, БХД) 2.4-5.8 хувиар буюу 795.8-844.2 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 7 дүүрэг (НД, СХД, ЧД, СБД, БГД, БЗД, ХУД) 2.5-11.6 хувиар буюу 899.1-52,766.9 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн.	1	396,918.7	1	396,918.7
3	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/560 дугаар захирамжаар тухайн дүүрэг, хорооны хэрэгцээ, шаардлагыг харгалзалгүйгээр хороо бүрт 50.0 сая төгрөгийг нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн эвдрэл гэмтэл, засварлах ажлын зардалд нийт 10,200.0 сая төгрөг хуваарилсан, БХД нь дүүргийн Засаг даргын захирамжгүйгээр 93.7 сая төгрөг зарцуулсан, СХД 2,150.0 сая төгрөг, БНД 155.2 сая төгрөгийг зарцуулахдаа шууд гэрээ байгуулж, зарцуулсан байна.	1	2,398.9	1	2,398.9
4	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад ТАХ-ний нэрийг “Бусад” гэсэн ерөнхий нэрийн дор 4,118.2 сая төгрөгөөр, он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад ТАХ-ний нэрийг “Бусад” гэсэн ерөнхий нэрийн дор 5,666.0 сая төгрөгөөр, мөн “Бүтээн байгуулалт, тохижилтын ажил, хөрөнгө оруулалт” гэсэн ерөнхий нэрийн дор 4,084.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна.	1	13,868.4	1	13,868.4
5	Нийслэлийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөж, зарцуулсан байна.	1		1	
6	Төрд учруулсан хохирлыг төлүүлэх 1,069.9 сая төгрөгийн хуримтлагдсан авлага үүссэнийг барагдуулах албан шаардлага өгсөн талаар ТАБ-д бүртгэлтэй байгаа боловч хариуцсан албан тушаалтан аудит хийхэд шаардагдах тулган баталгаажуулах мэдээллийг ирүүлээгүй байна.	1	-	1	-
7	НЗД-ын 2025 оны 921 дүгээр захирамжаар ашигтай ажилласан 9 орон нутгийн өмчит байгууллагын удирдлагуудад зорилтот түвшингээс давсан цэвэр ашгийн 20 хүртэл хувиар 1,657.5 сая төгрөгийн буюу хэт өндөр урамшуулал олгохоор шийдвэрлэж, алдагдалтай ажилласан 31 байгууллагын хувьд алдагдал бууруулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	987.1	1	987.1
8	Нийслэлийн ЗДТГ болон БНХАУ-ын “Хао Юань Групп” ХХК, “Тяньжин ӨүБайВэй” ХХК-иудын түншлэлтэй байгуулсан “Туулын хурдны зам” барих НХААГ/20250101139 дугаар бүхий ажил гүйцэтгэх гэрээний 2,345,049.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн 500,000.0 сая төгрөгөөс тайлант онд 401,000.0 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тус мега төслийн үйл ажиллагаа зогссон байна.	1	401,000.0	1	401,000.0

9	Зорилтот түвшнийг оновчтой төлөвлөөгүйгээс өөрийн үйл ажиллагаагаар орлого бүрдүүлж ажилладаг 14 ААНБ-ын орлого тасарчээ.	1	42,649.4	1	42,649.4
10	Нийслэлийн Засаг дарга нь нийт 14 ОНӨҮГ-тай гэрээ байгуулж, эдийн засгийн зорилтот түвшинг батлаагүй байна.	1	-	1	-
11	Хүнс хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг 5 байгууллага /Асгат хүнс ОНӨААТҮГ, Хүнс хангамж ОНӨААТҮГ, Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ, Багачууд хүнс ОНӨААТҮГ, Налайх хангамж ОНӨААТҮГ/ нь зах зээлийн үнээс өндрөөр хүнсний бүтээгдэхүүн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагуудад нийлүүлж байгаа нь төсвийн байгууллагуудад хүндрэл учруулж, цаашлаад хоолны чанарт сөргөөр нөлөөлж байна. Дээрх хүнс хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын 2025 оны борлуулалтын орлогыг 32,886.2 сая төгрөг байхаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 29,865.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөө 10.1 хувиар тасарчээ.	1	-	1	-
12	Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй 2 байгууллага, нэгж нийслэлийн төсвөөс 124.4 сая төгрөгийг цалин, НДШ-ийн зардалд зарцуулсан байна. /Багахангай Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ 62.8 сая төгрөг, Хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл 61.6 сая төгрөг/	1	124.4	1	124.4
13	Шилэн дансны цахим хуудаст зардлын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт зэрэг 8 мэдээллийг байршуулаагүй, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хугацаа хоцроож байршуулсан, 1-8 дугаар саруудад эхний 9 сарын мэдээллийг байршуулсан, мэдээлсэн дүн хуулганы дүнгээс зөрсөн, аудитын явцад Нийслэлийн Засаг даргын гаргасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг ирүүлээгүй тул мэдээлбэл зохих дүнтэй тулгах боломжгүй байна. /ТЕЗ/	1		1	
14	Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээг мэдээлээгүй болон хугацаа хоцроож байршуулсан байна. /Ногоон-Улаанбаатар орон сууц төслийн нэгж 166.5 сая төгрөг, Хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төслийн нэгж 101.0 сая төгрөг/	1	267.5	1	267.5
	ДҮН	14	858,214.4	14	858,214.4

Хавсралт 1. Нийслэлийн орлогын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан, (сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,222,915.5	3,825,996.8	(396,918.7)	90.6
3.1.01.1.1 Татварын орлого	3,563,968.1	3,210,667.8	(353,300.3)	90.1
3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	2,991,900.9	2,701,318.6	(290,582.2)	90.3
3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	2,103,800.9	1,935,352.7	(168,448.2)	92.0
3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	1,568,405.8	1,399,980.7	(168,425.2)	89.3
3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	57,096.8	60,223.2	3,126.4	105.5
3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	164,210.6	180,959.5	16,748.9	110.2
3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	121,715.4	112,419.9	(9,295.5)	92.4
3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	192,372.3	181,769.5	(10,602.8)	94.5
3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(52,800.0)	(52,466.9)	333.1	99.4
3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(52,800.0)	(52,466.9)	333.1	99.4
3.1.01.1.1.1.4 ААН-ын орлогын албан татвар	940,900.0	818,432.9	(122,467.1)	87.0
3.1.01.1.1.1.4.01 ААН-ын орлогын албан татвар	940,900.0	818,432.9	(122,467.1)	87.0
3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	238,485.9	235,502.3	(2,983.6)	98.7
3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	117,445.9	113,536.1	(3,909.8)	96.7
3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	506.3	480.8	(25.5)	95.0
3.1.01.1.1.3.3 Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	120,273.7	121,256.3	982.6	100.8
3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	260.0	229.2	(30.8)	88.1
3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	333,581.3	273,846.9	(59,734.5)	82.1
3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	102,059.0	90,923.3	(11,135.7)	89.1
3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	64,418.5	54,706.8	(9,711.8)	84.9
3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,003.3	715.8	(287.5)	71.3
3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	36,637.1	35,500.7	(1,136.4)	96.9
3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	191,861.0	140,066.2	(51,794.8)	73.0
3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	102,361.0	91,542.3	(10,818.7)	89.4
3.1.01.1.1.8.2.02 Дуудлага худалдаа	89,500.0	48,523.9	(40,976.1)	54.2
3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,854.8	4,671.5	(183.3)	96.2
3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	29.4	54.8	25.4	186.6
3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4,825.4	4,616.7	(208.7)	95.7
3.1.01.1.1.8.4 Бусад татвар	34,806.5	38,185.8	3,379.3	109.7
3.1.01.1.1.8.4.02 Нийслэл хотын албан татвар	34,806.5	38,185.8	3,379.3	109.7
3.1.01.1.2 Татварын бус орлого	658,947.4	615,329.0	(43,618.4)	93.4
3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	619,410.7	576,168.4	(43,242.3)	93.0
3.1.01.1.2.1.1 Хувьцааны ногдол ашиг	1,533.8	2,047.0	513.2	133.5
3.1.01.1.2.1.2 Хүүгийн орлого	265,616.9	241,520.1	(24,096.7)	90.9
3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	160,255.3	143,731.6	(16,523.7)	89.7
3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	49,012.3	57,283.0	8,270.8	116.9
3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	3,276.8	2,499.5	(777.2)	76.3
3.1.01.1.2.1.6 Түрээсийн орлого	3,068.9	2,644.2	(424.7)	86.2
3.1.01.1.2.1.9 Бусад орлого	136,646.8	126,442.8	(10,204.0)	92.5
3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	39,536.7	39,160.6	(376.1)	99.0
3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	39,536.7	39,160.6	(376.1)	99.0

Хавсралт 2. Төсөвт байгууллагын өөрийн төсвийн орлогын биелэлт, (сая төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	1,300.0	2,425.4	1,125.4	186.6
2	Нийслэлийн Орон сууцны бодлогын газар	-	0.7	0.7	
3	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	10.0	18.2	8.2	181.8
